МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2020 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ 12 ДУГААР САРЫН 17-НЫ ӨДӨР /ПҮРЭВ ГАРАГ/-ИЙН НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН ТОВЬЁГ

№	Баримтын агуулга	Хуудасны дугаар
1.	Хуралдааны товч тэмдэглэл:	1-15
2.	Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	16-141
	1.Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2020.05.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжилнэ/	17-20
	2.Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн нарын 8 гишүүн 2020.04.22-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	20-53
	3.Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Л.Энх-Амгалан, Ж.Ганбаатар нарын 2019.12.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	53-64
	4.Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар 2020.05.07-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	65-92
	5.Эрдэнэсийн сангийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ, С.Бямбацогт, Л.Мөнхбаатар нарын 3 гишүүн 2020.01.13-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	92-106
	6.Батлан хамгаалах салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2020.12.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/	106-108
	7.Далайчныг сургах стандарт, гэрчилгээ олгох болон ээлжийн ажиллагааны тухай олон улсын конвенцын нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2020.12.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/	109-119
	8.Олон Улсын Эрүүгийн шүүхийн дархан эрх болон эрх ямбын тухай хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2020.12.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/	119-121

ТОВЧ ТЭМДЭГЛЭЛ

Хоёр.Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүд */Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн нарын 8 гишүүн 2020.04.22-ны өдөр өргөн мэдүүлсэн,* ***эцсийн хэлэлцүүлэг****/*

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн багш Д.Ганзориг, Улсын Бага Хурлын гишүүн, Улсын Их Хурлын гишүүн асан Ц.Товуусүрэн, Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, дэд профессор, Хууль зүйн ухааны доктор А.Бямбажаргал нар “Их хуралдай” танхимаас оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Н.Цогтсайхан, Хууль, эрх зүйн газрын дарга Э.Түвшинжаргал, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Батбаатар, Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Болормаа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар "Үндсэн хууль" танхимаас танилцуулав.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, Ц.Даваасүрэн, Ш.Адьшаа, Ц.Сандаг-Очир, Т.Доржханд, Х.Ганхуяг, Ж.Ганбаатар, Ц.Мөнхцэцэг, Ж.Батсуурь нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Л.Энх-Амгалан, Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн багш Д.Ганзориг нар "Их хуралдай" танхимаас, Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар "Үндсэн хууль" танхимаас хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаар Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалтыг MyParliamemt программыг ашиглан явуулав.

Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн санал:

Г.Занданшатар: 1.Төслийн 7 дугаар зүйлд нэмсэн 7.2 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг, Х.Ганхуяг нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 39
Татгалзсан: 22
Бүгд: 61
63.9 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар, Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг, Ж.Батсуурь, Б.Бат-Эрдэнэ нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 36
Татгалзсан: 24
Бүгд: 60

60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Төслийн 12 дугаар зүйлд нэмсэн 12.1.9 дэх заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 35
Татгалзсан: 25
Бүгд: 60
58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Төслийн 25 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“25 дугаар зүйл. Дүүргийн чиг үүрэг

25.1.Дүүргийн чиг үүрэгт дараах асуудал хамаарна:

25.1.1.дүүргийн хөгжлийн үндсэн чиглэл, бодлого, төлөвлөлт, ерөнхий ба хэсэгчилсэн төлөвлөгөө*;*

25.1.2.дүүргийн өмчийн ашиглалт, эзэмшилт, захиран зарцуулалт, хяналт*;*

25.1.3.дүүргийн төсөв, түүний төлөвлөлт, гүйцэтгэл, тайлан, хяналт*;*

25.1.4.хууль тогтоомжид заасан хүрээнд татвар, хураамж, төлбөрийн хувь хэмжээ тогтоох асуудал*;*

25.1.5.дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлт, хуваарилалт, тайлан, хяналт, бусад сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, тайлан, хяналт*;*

25.1.6.худалдаа, үйлчилгээний зөвшөөрөл, хяналт*;*

25.1.7.нийслэлийн хүнс, хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн хөтөлбөрийн хэрэгжилт*;*

25.1.8.дүүргийн цэцэрлэг, сургууль, эмнэлэг, соёлын төв, номын сан, биеийн тамир, спортын цогцолборын барилга, байгууламж, хөдлөх хөрөнгийн ашиглалт, засвар, үйлчилгээ*;*

25.1.9.дүүрэг дэх авто зогсоолын арчилгаа*;*

25.1.10.нийтийн эзэмшлийн зам, талбай, олон нийтийн соёл амралтын хүрээлэн, ногоон байгууламж, арчилгаа, хамгаалалт*;*

25.1.11.оршуулгын газрын үйл ажиллагааны зохицуулалт*;*

25.1.12.дүүргийн гэрэлтүүлэг, арчлалт*;*

25.1.13.дүүргийн төвлөрсөн бус хүн амын унд, ахуйн хэрэгцээний уст цэгийн төлөвлөлт, байршил, ашиглалт, хамгаалалт*;*

25.1.14.хог хаягдлын менежмент.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа, Л.Мөнхбаатар, Б.Пүрэвдорж нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 36
Татгалзсан: 24
Бүгд: 60
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Төслийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“47.6.Улсын хэмжээний бодлого дэвшүүлж ажиллах үүрэг бүхий улс төрийн нам, эвсэл сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүтцэд аливаа хэлбэрээр зохион байгуулалтын нэгж байгуулахгүй.

Тайлбар: Энэ хэсгийг 2024 оны орон нутгийн ээлжит сонгуулийн дараа өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 36
Татгалзсан: 24
Бүгд: 60
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Төсөлд доор дурдсан агуулгатай 77 дугаар зүйл нэмж, дугаарлалтыг өөрчлөх:

“77 дугаар зүйл. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн гадаад хамтын ажиллагаа

77.1.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн гадаад хамтын ажиллагаа нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын болон гадаад бодлогын үзэл баримтлалд нийцсэн, гадаад бодлогын нэгдмэл байдлыг баримталсан байна.

77.2.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж нь өөрийн эрхлэх асуудлын хүрээнд гадаад улсын адил түвшний, эсхүл олон улсын байгууллагатай байгууллага хоорондын гэрээ байгуулж болох бөгөөд гэрээг байгуулахдаа гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрөл

авсан байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшин, Б.Пүрэвдорж, Ж.Бат-Эрдэнэ нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 38
Татгалзсан: 22
Бүгд: 60
63.3 саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

Г.Занданшатар: “Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийг хэрэгжүүлэх бэлтгэлийг хангах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 42
Татгалзсан: 19
Бүгд: 61
68.9 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 12 цаг 15 минутад хэлэлцэж дуусав.

ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Дараагийн асуудалд орно. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Жамъянхорлоогийн Сүхбаатар Үндсэн хуулийн танхимаас танилцуулна.

Ж.Сүхбаатар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Тогтохсүрэн, Нямбаатар, Мөнх-Оргил, Баатарбилэг, Бямбацогт, Лүндээжанцан, Амарзаяа, Батзандан, Ганболд нар 2020 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Засаг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2020 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаараа хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Тус Байнгын хороо 2020 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын санал авсан саналуудыг төслийн холбогдох зүйл, заалт, хэсэгт нэмж тусган, төслийн агуулга, бодлого, зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, дэс дараалал, бүтцийн шинжтэй засварыг хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн хууль, тогтоолын төслүүд болон зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг та бүхэнд тараасан болно.

Төрийн байгуулалтын байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2-ын 1 дэх заалтад заасны дагуу нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлэг явуулах үед төслийн зарим зүйл, заалтыг хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгсөн. Энэхүү чиглэлийн дагуу төслийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийг хасах, дүүргийн чиг үүргийн өөрчлөн найруулах, төслийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсгийг улсын хэмжээний бодлого дэвшүүлж ажиллах үүрэг бүхий улс төрийн нам, эвсэл, сум, сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын бүтцэд аливаа хэлбэрээр зохион байгуулалтын нэгж байгуулахгүй. Энэ хэсгийг 2024 оны ээлжит сонгуулийн дараачаас эхлэн мөрдөнө гэж өөрчлөн найруулах, мөн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42.2-ын 3-т заасны дагуу нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлгээр санал хурааж шийдвэрлэсэн боловч Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь дахин санал хураалгах шаардлагатай гэж үзсэн.

Төслийн 12 дугаар зүйлд 12.1.9 дэх заалт нэмэх гэснийг, 7 дугаар зүйлд 7.2 дахь хэсэг нэмэх гэснийг тус тус хасах, мөн төсөлд 6 дугаар бүлэг нэмж, засаг засаг захиргаа, нутгийн дэвсгэрийн нэгжийн гадаад хамтын ажиллагааг зохицуулсан 77.1, Засаг захиргаа, нутаг дэвсэрийн нэгжийн гадаад хамтын ажиллагаа нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын болон гадаад бодлогын үзэл баримтлалд нийцсэн гадаад бодлогын нэгдмэл байдлыг баримталсан байна.

77.2. Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж нь өөрөө эрхлэх асуудлын хүрээнд гадаад улсын адил түвшний, эсхүл олон улсын байгууллагатай байгууллага хоорондын гэрээ байгуулж болох бөгөөд гэрээг байгуулахдаа гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрөл авсан байна гэсэн зүйлийг нэмэхээр санал хураалгаж шийдвэрлүүлэв.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засаг, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслүүд болон Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль, шинэчилсэн найруулгыг хэрэгжүүлэх бэлтгэлийг хангах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Баярлалаа. Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй 6 саналаар санал хураалт явуулна. Үүнийг цахимаар явуулах учраас гишүүд тоног төхөөрөмжийн бэлтгэлийг хангаарай.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүн байна уу. Дараа нь 6 саналаар санал хураана. Доржханд гишүүнээр тасаллаа.

Эрхэм гишүүн Сандагийн Бямбацогт.

С.Бямбацогт: Энэ төслийн 47 дугаар зүйл дээр улсын хэмжээний бодлого дэвшүүлж ажиллах үүрэг бүхий улс төрийн нам эвсэл, сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын бүтцэд аливаа хэлбэрийн зохион байгуулалтын нэгж байгуулахгүй гэсэн заалт өөрчилж байгаа юм байна. Үүнийг тэгээд 2024 оны орон нутгийн ээлжит сонгуулийн дараа өдрөөс эхэлж дагаж мөрдөнө гээд. Өөрөөр хэлбэл үүнтэй холбоотойгоор үндсэндээ нөгөө суманд улс төрждөг байдлыг таслан зогсоох чиглэлд илүү хүчтэй заалт болж байна уу? Эсвэл одоо сулруулсан заалт болчхоод байна уу? Нэг талаасаа бид нар суманд аль болох улс төржихгүй байх, ард иргэдийг авгай, нөхрөө, ах, дүү нар талцуулахгүй байх энэ тал руу чиглэсэн бодлого явуулах ёстой гэж үздэг.

Нөгөө талаас бас улсын хэмжээний, үндэсний хэмжээний нам суманд бүтэцтэй байх гэдэг асуудал яригддаг. Тэгээд энэ дээр манай ажлын хэсэг маань одоо юу гэж үзэж байгаа юм бол. Цаашдаа эндээс харвал үндсэндээ суманд бол улс төржихгүй байх ийм бололцоо, боломж руу чиглэсэн ийм алхмууд хийгдэж эхэлж байгаа юм байна. Нэгжийн хуулиар гэж харж байна.

Тэгээд энэ дээр яг ямар агуулгаар үүнийг оруулж ирж байгаа энэ заалтыг үүнийг нэг тодорхой хариулж өгөөч.

Г.Занданшатар: Хэн хариулах вэ. Жамъянхорлоогийн Сүхбаатар дарга Үндсэн хуулийн танхимаас, ажлын хэсгийн дарга хариулна.

Ж.Сүхбаатар: Эрхэм гишүүн Бямбацогтын асуултад хариулъя. Анх хууль санаачлагчид төсөл дээр та бүхэн оруулж ирэхдээ улс төрийн нам эвсэл, иргэдийн төлөөлөгчдийн хурлын бүтцэд аливаа хэлбэрийн нэгж байгуулахгүй гэдэг ийм заалт оруулж ирсэн. Улс төрийн нам бол сонгуульд нэр дэвшүүлэхгүй гэдэг ийм концепцтой орж ирсэн.

Тэгэхээр энэ заалт бид нарын энэ төсөл дээр ажилласан заалт бол гишүүдийн болон Ардчилсан нам, Ардын намын бүлгийн байр суурийг авч үзээд томьёолсон ийм санал юм байгаа юм. Тэгэхээр энэ бол төсөлтэй харьцуулах юм бол нэлээн зөөлөрсөн ийм заалт. Гол зорилго бол сумын түвшинд ямар ч байсан нам нэр дэвшүүлэхгүй гэдгийг бол энэ намын реформын асуудал ирэх жил яригдана. Үндсэн хуульд бид нар чинь өөрчлөлт оруулахдаа улс төрийн нам бол үндэсний хэмжээнд бодлого дэвшүүлж ажиллана гээд заачихсан. Энэ нь шууд утгаараа аймаг нийслэлээс дээш түвшинд ажиллахыг шахаж шаардчихсан байгаа юм. Үндсэн хуулийн заалт.

Тэгэхдээ энэ реформын асуудал тусад нь яригдах учраас би нэгжийн хууль дээр бидний баримталсан бодлого бол аль болохоор улс төрийн яг маргааны сэдэвт оруулахгүй байж нэгжийнхээ хуулийн үндсэн асуудлыг шийдээд явъя. Гэхдээ нэг том алхам хийе. Сумын түвшинд нам нэр дэвшүүлэх боловч тэр гарч ирсэн нам эвсэл нь иргэдийн хуралдаа бүлэг байгуулж бүлгэрхэж намын бүлэг хэлбэрээр ажиллах ийм шаардлагагүй юм. Яагаад гэвэл үндэсний хэмжээнд бодлого дэвшүүлж ажиллах учраас. Сумын түвшинд бол үндэсний хэмжээний бодлого гэж намын бүлэгт бол байхгүй юм гэдэг утгаар суман дээр тавьсан ийм асуудал байгаа.

Ер нь цаашдаа яригдах болохоор дүүргийн түвшинд бас байж болохыг хууль тогтоогчид бол зөвшөөрч магадгүй юм байгаа. Тэгэхээр энийг бол анх сумаас нь бол ямар ч байсан ийм байдал нь тодорхой учраас Үндсэн хуулийнхаа шаардлагыг эхний ээлжинд намын бүлэг . ../хугацаа дуусав/.

Г.Занданшатар: Одоо Жанжин Д.Сүхбаатарын танхимаас эрхэм гишүүн Цэрэнпилийн Даваасүрэн асуулт асууна.

Ц.Даваасүрэн: Баярлалаа. Та бүгдэд энэ өдрийн мэнд хүргэе. Би 3 зүйлийг тодруулах гээд байгаа юм. Энэ хууль үнэхээр чухал суурь хуулиудын нэг болно. Тийм учраас амьдрал баян учраас цөөнх ч болох цаг ирнэ гэж ингэж л бодож бид нар хандах ёстой байх. Тухайлбал энэ хуулийн хуучин заалтаараа бол 48.7. Тэгээд одоогийнхоор энэ өөрчлөлт ороод ирэхээр 56.7 болж байгаа юм шиг байгаа юм байна. Дээд шатны засаг дарга Ерөнхий сайд нэр дэвшигчийг шууд татгалзаж болно гэж байгаа юм. Хууль зүйн үндэслэлээр гэж хэлэхгүй байгаа юм. Хууль зүйн үндэслэл гэж хэлэхгүй байгаа юм. Зүгээр л татгалзаж болно гэж. Тэгээд энэ бол их төвөгтэй. Жишээлбэл одоо бүр багаас эхлээд бүх л шатанд энэ явагдана. Суман дээр тэр. Багаас иргэд нийтийн хурлаараа гарч ирж байгаа

хүнийг нь манай намын хүн биш гээд л ингээд л томилж өгөхгүй байх. Тэгээд өөрөө оролцож нэр дэвшүүлнэ энэ тэр гээд.

Хэрвээ улс төрийн олон намуудын тогтолцоотой тэгээд Үндсэн хуулиараа нутгийн өөртөө удирдах ёсны энэ засаглалаа хэрэгжүүлээд явна гэж байгаа бол энэ заалт маш төвөгтэй байдал руу оруулна. Амьдралтай уялдаатай бас нэг гарч ирэх юм бол нийтийн хурлын ээлжит хуралдааныг одоо нэг удаа хуралдуулна гэчхээд байгаа юм. 48.1.1 чинь. Энэ улиралд нэгээс доошгүй байх, амьдрал баян шүү дээ. Одоо ингээд л ковид гээд л янз бүрийн юм гарч ирж байна. Тийм учраас нэгээс доошгүй гэж уг нь авч үзэж болоогүй юм уу гэдгийг бас би тодруулъя гэж бодоод байгаа юм.

Мөн хурлын хороо ингээд одоо хурлын тасралтгүй үйл ажиллагааг хангана гээд тэр нь төлөөлөгчдөөсөө бүрдээд байгаа юм. Төлөөлөгч нь янз бүрийн байдлаас, янз бүрийн газар, орон нутагт амьдарч байгаа. Тийм болохоор тэд нар байнга оролцоод энэ хурлын тасралтгүй үйл ажиллагааг хангаад байж ингэж чадахгүй бол уу? Ер нь бол өнгөрсөн хугацаанд бол.../хугацаа дуусав/.

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Дондовын Ганзориг Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн багш, Цэдэвийн Товуусүрэн Улсын Бага Хурлын гишүүн, Улсын Их Хурлын гишүүн асан, Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн ажлын хэсгийн гишүүн, Алтангэрэлийн Бямбажаргал Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, дэд профессор, хууль зүйн ухааны доктор байна.

Жамъянхорлоогийн Сүхбаатар дарга хариулъя.

Ж.Сүхбаатар: Эрхэм гишүүн Даваасүрэнгийн асуултад хариулъя. Тэгэхээр бид нар энэ хуулиараа нэр дэвшигчид тавих шаардлагыг хийж өгсөн. Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны засаг даргад тавьж байгаа. Тухайлбал баг, хорооны засаг даргад бол дээд боловсролтой байх шаардлагыг тавьж байгаа. Гэхдээ 2024 оны ээлжит сонгуулийн дараа өдрөөс мөрдөхөөр ингээд заачихсан байгаа. Тэгээд ер нь татгалзахад бол хоёр янзаар л дээд шатны засаг дарга, Ерөнхий сайд татгалзсан л даа. Нэг нь бол саяын хэлдэг, шаардлага хангаагүй хүнийг дэвшүүлсэн байх юм бол нэг татгалзана. Одоо явж ирсэн практикаар бол ер нь энэ засаг дарга нар чинь бол засаг, төрийн төлөөлөгч буюу засгийн газрын төлөөлөгч байгаа юм. Тэгэхээр дээд шатныхаа дарга, Ерөнхий сайд бол бас өөрөө хуульд олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд Засгийн газрын мөрийн хөтөлбөр батлуулаад ингээд явж байдаг.

Тэгээд бодлогоо хэрэгжүүлэх бас тэр чинь хүний нөөцийн бодлогын баримталж байгаа улс төрийн бас шалгуур байгаа юм. Шууд хэлэхэд. Тэгэхээр энэ шалгуурынхаа үүднээс бас энэ хүнийг хэдийгээр хурал нэр дэвшүүлэх эрхтэй ч гэсэн нэг удаа татгалзаж байгаа юм. Дараагийн удаа бол татгалзах эрхгүй, хурал нь бол үндсэндээ тулгаад томилчихож байгаа шүү дээ. Манай энэ Үндсэн хуулийн явж ирж байгаа практикаар бол. Тэгэхээр Ерөнхий сайдын хувьд бол хэт давуу эрх бас эдэлж байгаа юм бол байхгүй байгаад байгаа юм. Тэгээд энийг бол

бүр зүгээр хуульд заасан үндэслэл гэвэл тэгээд дээд шатныхаа улсуудыг юм уу бүр л хязгаарлаад, зөвхөн хурал томилдог, тэгээд дээд шатных нь хүмүүс нь ёсчилдог гэдэг ийм ойлголтоор явчхаад байгаа юм. Үндсэн хуульд бол ёсчлох батламжлах агуулга бол байхгүй байгаад байгаа юм томилно гэж. Тэгээд аль аль нь тэнцвэржүүлж хийх гэж байгаа ийм санаа.

Хоёрдугаарх асуудал бол улиралд нэг удаа хуралдана гэдгийг нэгээс доошгүй удаа санал ирсэн. Үүнийг бол бид ээлжит хурлыг зааж өгсөн байгаа. Тэгээд улиралд наана нь ингээд хуралдах шаардлага гарахаар ээлжит бус хуралдаанууд явах боломжууд нь байж байгаа юм.

Гуравдугаарт хурлын хороодын асуудлыг та хөндөж байна. Шинэ зохион байгуулалтад шилжиж байгаа. тэгээд тэргүүлэгчид гээд дарга, тэргүүлэгчийн тогтолцоог халаад хурлын.../хугацаа дуусав/.

Г.Занданшатар: Ганзориг ажлын хэсгийн гишүүн 84 дүгээр микрофон.

Д.Ганзориг: Баярлалаа. Даваасүрэн гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр сая ажлын хэсгийн ахлагчийн хариулсан дээр нэмж нэг зүйлийг хэлэхэд ер нь бол энэ иргэдийн төлөөлөгчдийн ээлжит хуралдаан хэр их олон удаагийн давтамжтай явагдах уу гэдэг талаар их өөр өөр байр сууриуд байдаг юм байна. Тэгээд бид бас энэ талаар санал авч байсан. Тэгээд зарим тохиолдолд улиралд нэг удаа буюу жилд 4 удаа хуралддаг чинь өөрөө олон байна гэсэн саналууд ирж байсан. Тэгээд ер нь хамгийн дундаж вариант нь юу юм бэ гэхээр энэ жилд хамгийн минимум бол 4 удаа хуралдаад явах тухай асуудал нь хамгийн зөв зүйтэй юм байна гэсэн ийм хувилбарыг ажлын дэд хэсэг болон ажлын хэсэг дээр ярилцаж байгаад ийм зүйлийг хийсэн байгаа юм.

Бусад хуралдааны хувьд бол ээлжит бус хуралдаануудыг зарлан хуралдуулж болно. Тэгээд энэ бүх нарийн нарийвчилсан асуудлуудаа иргэдийн төлөөлөгчдийн хурал дотроо өөрсдөө бас өөрөө удирдах сны хүрээнд шийдвэрлээд явах боломж нь нээлттэй байгаа юм ийм байдлаар нэгдүгээрт хариулъя.

Хоёрдугаарт, засаг даргыг томилох тухай асуудал дээр ер нь Үндсэн хуулийн 60.3-ын дээд шатны засаг дарга эсхүл Ерөнхий сайд томилно гэдэг энэ үгийг Үндсэн хуулийн эрх зүйн талаас нь, эсхүл ер нь эрх зүйн онолын талаас нь юу гэж тайлбарлах юм бэ гэдэг дээр нэлээн их маргаан яваад байгаа юм. Энийг томилно гэдгийг эрх олгосон хэм хэмжээ гэдэг утгаар ойлгох юм уу? эсхүл үүрэг болгосон хэм хэмжээ гэдэг утгаараа ойлгох юм уу гэдгийг. Яг энэ томилно гэдэг үгийн хувьд бол. Тэгэхээр бид бол тайлбар, зөвхөн дан ганц энэ 60.3 гэдэг энэ утгаар авч үзээгүй. Юу вэ гэхээр энэ бол бүхэлдээ Үндсэн хуулийн 1.2-той холбоотой, Үндсэн хуулийн 60.1-тэй холбоотой, Үндсэн хуулийн 61.1-тэй холбоотой гэдэг утгаараа.../Хугацаа дуусав/.

Г.Занданшатар: Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн тодруулна.

Ц.Даваасүрэн: Баярлалаа. Тэр 58.7-д болохоор тэгээд зүгээр л шууд татгалзана гээд хэлчихсэн болохоос биш тэр шалгуур шаардлагыг хангаагүй тохиолдолд гэдэг юм уу, хуулийн шаардлагыг хангаагүй тохиолдолд гэж үг оруулчихаж яагаад болоогүй. Тэгвэл болно л доо. Энэ чинь ямар ч үндэслэлгүйгээр зүгээр л татгалзлаа гэж хэлчихээр болоод байгаа юм. Тэгээд дараагийн 8-аараа өөр хүний нэрийг дэвшүүлнэ гэсэн байна. Тэгээд тэр хүн тэгээд л дуусчихаж байгаа юм. Одоо Ерөнхий сайд юм уу, дээд шатны дарга нь татгалзахад тэгээд л дуусчихсан. Ялангуяа наадах чинь баг дээр, сум дээр зовлонтой нөхцөл байдал үүсэх нь ээ.

Ээлжит бус хуралдааны хувьд бас тодорхой шалгууруудтай шүү дээ. Төлөөлөгчдийн гуравны нэг тэгээд зөвлөл, эсвэл иргэдийн хурлын дарга хуралдуулна гээд. Ингээд наадах чинь бас ээлжит бус хуралдаан дээрээ ингээд нөхцөлүүд тавьчихсан учраас нэг тийм хурлын асуудал чинь уг нь байнга хуралдах боломжтой байхаар хуульчилж өгвөл уг нь зүгээр байгаа юм л даа. Тэрийгээ сайн бодоорой, амьдрал баян.

Г.Занданшатар: Ер нь энэ Үндсэн хуульд томилно гэдэг үг хэд байна аа? Тэр үг болгон дээр одоо яаж зохицуулж байна? Ганзориг дарга аа. 84.

Д.Ганзориг: Тэгэхээр захиргааны эрх зүй, Үндсэн хуулийн хэмжээнд бол томилно гэдэг энэ ойлголтыг илүү их, эрх гэдэг ийм утгаар нэлээн их тийм ойлгодог ийм тайлбарууд бий л дээ. Одоо Чимид багшийн цагаан номоос эхлүүлээд ингээд. Тэр томилж байгаа талдаа илүү их тийм боломжууд нь байх ёстой юм гэдэг ийм талаасаа. Ер нь томилно гэдэгтэй холбоотой жишээлэх юм бол Ерөнхий сайдыг томилохоос эхлүүлээд энэ Үндсэн хууль дээр шууд томилогддог албан тушаалтан гэвэл дор хаяж 5-6 байгаа. Жишээлбэл Үндсэн хуулийн цэцийн гишүүнийг томилно, засаг даргыг томилно, шүүгчийг томилно гэсэн.

Тэгэхээр үүнийг хэрэв бид нар эрх зүйн онолын үүднээс эрх гэдэг утга руу нь илүү их тайлбарлаж явбал сая Даваасүрэн гишүүний тавьсан хязгаарлалтуудыг хийж болох уу, үгүй юу гэдэг дээр л гацчихаад байгаа юм.

Г.Занданшатар: Үүнийг ингээд нэг мөр ойлгохгүй бол 5-6 байхгүй л дээ. 30 дугаар зүйл, 5 дугаар бүлэг, 6 дугаар бүлэг, Үндсэн хуулийн 3, 4дүгээр бүлгүүд дээр томилно гэсэн үг засаг даргаас авхуулаад, тэгээд Ерөнхий сайд, сайд нар, тэгээд шүүх хүртэл томилно гэдгийг нэг утгатай ойлгохгүй бол одоо энэ дээр өөрөөр хэлбэл дараа нь шүүхийн томилно гэсэн үг дээр яг энэ призидент чинь давтагдана шүү дээ. Тэгээд үүнийг зөвхөн энэ бүлэгтэй холбогдуулж томилно гэдэг бол үгийг ингэж салаа утгатай тайлбарлаж болохгүй л дээ, бас.

Цэрэнпилийн Даваасүрэн гишүүндээ төрсөн өдрийн баярын мэнд хүргэе. Нэг минут олгоё.

Ц.Даваасүрэн: Энэ тэгэхээр саяын хариултаас би дахин тодруулъя. Наадах чинь эргэлзээтэй байдалд оруулчихна шүү дээ. Одоо ингээд нөгөө нэг

хуулийн шаардлагууд тавьж өгөөд томилно гэхээр асуудалтай болчхоод байна аа гэж. Тэгэхээр ийм хууль гаргаж болохгүй шүү дээ. Тэгээд ингээд одоо хууль баталж байгаа бид нар нь эргэлзээтэй ийм юм баталчихаар чинь цаанаа очоод одоо хэн тайлбар өгөх вэ, Цэц рүү явах вэ гээд ингээд төвөгтэй юмнууд үүснэ.

Ер нь бол Үндсэн хуулийн нутгийн өөртөө удирдах ёсны асуудлаа одоо бид нар бас л энэ чинь одоо бодолцохгүй бол болохгүй шүү дээ. Үндсэн хуулийн зөрчил рүү ороод тэгээд наадах чинь Цэц рүү очоод ингээд нэг хачин юмнууд болох вий л гэж бодоод байгаа юм. Ингээд Үндсэн хууль дээр хоёр агуулгатай юм орчихсоноос ийм нөхцөл байдал үүсээд байна. Тэгэхээр үүнийгээ, бас бид нар үүнийгээ нэлээн сайн ярьж, хэлэлцүүлэг дээр анхаарч ингэж шийдвэрлэхгүй бол болохгүй юм байна аа гэдэг нь та бүгдийн хариултаас харагдаад байна шүү дээ.

Г.Занданшатар: 84.

Д.Ганзориг: Тэгэхээр энэ дээр томилно гэдгийг хэрэв эрх зүйн онолын үүднээс энэ бол эрх олгосон хэм хэмжээ гэдэг утгаар бид нар 100 хувь ойлгоод, ингээд цаашдаа явбал. Бид нар бол ер нь хуульчид тэгж хардаг. Гэхдээ ганцхан томилно гэдэг энэ үгийг энэ заалттай нь холбогдуулж биш бусад заалтуудтай нь холбож байж -за одоо энэ засаг даргыг бол яах аргагүй Ерөнхий сайд эсхүл дээд шатны засаг дарга нь томилох юм. Томилно гэдэг нь бол энэ бол эрх утгаар ойлгогдох юм байна гэж ингэж тайлбарлаж байгаа юм. Үндсэн хуулийн 60.3 дээр нэр дэвшигчийг томилохоос татгалзвал гэсэн үг байгаа.

Хэрэв нэр дэвшигчийг томилохоос татгалзвал гэдэг дээр бид нар тодорхой нөхцөлүүдийг тавиад ирвэл харин ч эсрэгээрээ 60.3-ыг бид буруу тайлбарласан хэрэгт орох юм биш байгаа даа гэсэн нэг ийм хуульч нарын болгоомжлол байгаад байгаа юм. Тийм учраас одоогоор бол яаж байгаа вэ гэхээр тэр томилох эрхтэй этгээдэд нэг удаа тэр боломжийг нь өгье.

Г.Занданшатар: Жамъянхорлоогийн Сүхбаатар дарга Үндсэн хуулийн танхимаас хариулна.

Ж.Сүхбаатар: Би асуултад даргаа хариулмаар байгаа шүү. Тэр томилох дээр одоо эргэлзэж байна гэдэг чинь бол зүгээр эрдэмтэн хүний бодол шүү дээ. Тэрнээс биш бид нарын явж ирсэн юм чинь томилдог. Одоо энэ дээр Их Хурлын дарга хүн томилдог. Улсын Их Хурал хүн томилдог. Тэгээд томилгоонд чинь хоёр янзын л юм байгаа шүү дээ. Нэг нь улс төрийн албан тушаалтныг томилох процедур нэг өөр. Төрийн тусгай жинхэнэ албан хаагчийг чинь захиргааны албан хаагчийн чинь томилох процедур нэг өөр. Гэхдээ эцсийн дүндээ томилгоо бол томилох эрх шүү дээ. Нөхцөл зааж өгч байгаа. Бид нар бол харин энэ Үндсэн хууль дээр чинь ийм үндэслэлээр томилохоос татгалзана гэж заагаагүй байхгүй юу. Тэрийг чинь энэ хуулийн үзэмжийн бүрэн эрхийг чөлөөлж, энэ улс төрийн албан тушаалтнуудыг томилох дээр тухайн томилогч этгээдэд угаасаа олгодог нь ойлгомжтой асуудал.

Харин бид нар нэмж энэ засаг дарга нарт дээд боловсролтой байна шүү,

төрийн албанд ажилласан байна шүү, ялгүй байна шүү гээд ингээд явж байгаа, бүр нэмэлт шалгуур энэ Үндсэн хуульд тусгагдаагүй. Саяын тэр асуудлууд чинь Үндсэн хуулиар бол бүр тодорхой ямар ч үндэслэлгүйгээр зүгээр томилчихоод татгалзах эрхийг нь өгчихсөн байхгүй юу. Харин хууль тогтоогч цаг үе өөрчлөгдөж байгаа учраас сая тэр Ганзориг багшийн хэлээд байгаа шиг эрх гэдгээсээ гадна жаахан үүрэгжүүлье ээ, юмыг нь бас хумья аа. Дур зоргын юм бас байх вий гэж нэмэлт юм хийж өгч байгаа цаг үеийн энэ шаардлагаар.

Түүнээс томилогч тал өөрөө асуудлыг шийд гэснээс, одоо манай энэ хурал нэр дэвшүүлнэ, дээд шатны засаг дарга, Ерөнхий сайд томилно гэдэг зарчим чинь энэ Үндсэн хуулиар тогтчихсон. Тэгэхдээ одоо бодит байдал дээр нэр дэвшүүлсэн хурал нь эцэслэн шийдэж байгаа, ямар ч хүн байсан гэсэн наана нь цаана болсон ч гэсэн хурлын эцсийн шийдвэрээр шууд томилох үүргийг хүлээгээд байгаа. Харин энэ Үндсэн хуульд чинь томилох үүрэг хүлээнэ гээгүй, томилно гэж байгаа шүү дээ, тэр хүнд нь. Тэгэхээр би засаг төрийн төлөөлөгчийн тэр давуу эрхийг томилгооны системийг бий болгоё гээд өнгөрсөн жил ярьж байсан улсууд. Харин үүнийхээ юмыг нэг жижигхэн нэг алхам хийх гэж оролдож байгаа байхгүй юу. Тэрнээс биш шууд дээрээс томилдог болъё гээд.

Г.Занданшатар: Одоо эрхэм гишүүн Ширнэнбандийн Адьшаа Эзэн Чингис хааны танхимаас асуулт асууна.

Ш.Адьшаа: Эрхэм гишүүдийнхээ энэ өдрийн амгаланг айлтгая. Ажлын хэсгийн хэсгийн гишүүн Сүхбаатар даргаас 3 зүйлийг асууя гэж бодож байгаа. Монгол Улс бол нэгдсэн улс. Гэтэл энэ орон нутагт эрх мэдлийг шилжүүлнэ гэдэг энэ бодлогын хүрээнд орон нутагт татвар, концесс, бонд гаргах ийм эрх мэдлийг олгож байгаа. Тэгэхлээр энд одоо олон сөрөг үр дагавар гаргах ийм байдал бий болно гэсэн ийм болгоомжлол байгаа юм.

Байгалийн баялгийн үр өгөөжийг Монголын ард түмэн бүгд хүртэх ийм Үндсэн хуулийн эрхтэй. Гэтэл тэр Өмнөговь ч юм уу, өөр их ашигт малтмалтай газрын баялгийг зөвхөн Өмнөговийн ард түмэн хүртэнэ гээд энэ хуулийн чинь дагуу тухайн сумын иргэдийн хурал шийдвэр гаргаж баталгаажуулбал энэ нэгдмэл улсын чинь бодлоготой зөрчилдвөл үүнийг яаж зохицуулах юм.

Нөгөө талаасаа орон нутаг бүхэн өөр өөрийн татвартай, өөр өөрийн төсөвтэй ийм байдал нөхцөл бий болгох ийм хууль байгаа. Ийм учраас энэ улсын төсөв бүрдүүлэх, орон нутгийн төсвийг тухайн намаас гарч ирсэн хэсэг бүлэг хүмүүсийн бодлогоор явбал үүнийг яах юм бэ гэсэн ийм нэг асуулт байна.

Нөгөө талаар энэ шинэ Үндсэн хуулийн өөрчлөлтөөр …/хугацаа дуусав/.

Г.Занданшатар: Жамъянхорлоогийн Сүхбаатар дарга. Уг нь Байнгын хороо хариулах ёстой. Адьшаа гишүүн1 минут шууд тодруулах юм уу?

Ш.Адьшаа: Энэ Үндсэн хуулийн өөрчлөлтөөр улс төржилтийг зогсоох ийм бодлогын дагуу энэ хууль явагдаж байгаа гэж бодож байгаа. Гэтэл орон нутагт

улс төрийн нам нэр дэвшүүлж болохгүй гэсэн ийм заалт анхны төсөл дээр орж ирсэн байсан. Энэ төслийг ямар шалтгаанаар ингэж ажлын хэсэг авч хаяв аа? Ер нь энэ улс төржилтийг сум, орон нутагт ийм байдлаар байлгах ийм зорилго байгаа юм уу, аль эсвэл энэ орон нутагтаа энэ улс төржилт энэ намын харьяаллаас болж нийгэм одоо ийм эвгүй байдлыг засаж залруулахын төлөө, энэ хуульд яагаад энэ зарчмын өөрчлөлтийг оруулахыг одоо энэ удаа хойшлуулсан бэ гэдэг ийм асуултуудыг асууя.

Г.Занданшатар: Сүхбаатар дарга Үндсэн хуулийн танхимаас.

Ж.Сүхбаатар: Эрхэм гишүүн Адьшаагийн асуултад хариулъя. Яг таны хэлээд байгаа асуудлыг бол бид нар энэ ажлын хэсгийн түвшинд ч тэр, өмнө нь ч тэр, ер нь бол бид нараас өмнө ч тэр энэ орон нутгийн бие даасан байдлыг хангах, төвлөрлийг сааруулах асуудлын хүрээнд маш олон хэлэлцүүлэг, судалгаа явсан байдаг. Хамгийн сүүлийн бид нарын ажлын хэсгийн одоо энэ хийж байгаа хуультай уялдахад Монгол Улсын төсвийн төвлөрлийг сааруулах үйл явц, орон нутгийн эдийн засаг, санхүүгийн бие даасан байдлыг нэмэгдүүлэх арга зам гээд ийм судалгааны ийм материал гарсан байж байгаа.

Тэгээд бид нарын энэ гол юм бол юу юм бэ гэхээр энэ чиг үүрэг хуваарилж байгаа. Төв, орон нутгийн чиг үүргийг зааглах, орон нутгийн чиг үүргийг шат шатанд нь хуваарилах асуудал байгаа. Үүнийг дагалдаад тэр төсөв, өмч, томилгооны асуудлууд, салбар, салбар хуулиудаар цаашаа хийж өгөх юм. Энийг зөв суурийг нь тавьж байгаа гэж хэлж болно.

Таны хэлдэг асуудлаар зарим аймгууд одоо байгалийн баялаг ихтэй, зарим аймгуудын тухайд ямар асуудал байж болох вэ гэж. Бид нар төслийн энэ одоо бол 76.1 гэж явж байгаа. Энэ дээр ийм заалт хийж өгсөн байгаа. Үндсэн хуулийн Тавин есдүгээр зүйлийн хоёр дахь хэсэгт заасны дагуу засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн өөрийн удирдлагын чиг үүрэг, төсвийн харилцааны үндсийг тухайн нэгжийн газар зүйн байршил, хүн амын тоо, суурьшил, иргэдэд үзүүлэх үйлчилгээний хүртээмж, хил хамгаалалт, улсын эдийн засагт үзүүлэх нөлөө зэрэг тухайн нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн амьдралын тодорхой онцлогт нийцүүлэн хуулиар тусгайлан зохицуулж болно гэж заасан.

Ингэснээрээ бол цаашдаа тодорхой газрууд дээр бид нар энэ эрх зүйн тусгай ийм зохицуулалтын дэглэмтэй байлгах шаардлага бол байгаа. Тухайн одоо онцлогт нь тохируулсан. Тэгэхээр энэ асуудлаар бол явуулна аа, таны хэлдэг үнэн.

Монгол Улсад аль ч газар амьдарч байсан хүн төрийн буюу нийтийн үйлчилгээг хамгийн ойр иргэдэд үзүүлэх тэр үйлчилгээг нэг стандартаар нэг ижил хүртээмжтэйгээр авах тухай асуудал чухал байгаа. Тэгэхээр энэ хүртээмжийг бий болгох асуудал дээр энэ хууль бол бас боломжийг болгож чиглүүлсэн гэж хэлмээр байна.

Хоёрдугаарх асуудал нь бид нар энэ сум, дүүрэгт маш их

боломж. ../хугацаа дуусав/.

Г.Занданшатар:Одоо эрхэм гишүүн Цэндийн Сандаг-Очир Үндсэн хуулийн танхимаас асуулт асууна.

Ц.Сандаг-Очир: Баярлалаа. Би зарчмын хувьд дэмжиж байгаа, бас дэмжихгүй байгаа ганц нэг санаагаа хэлье. Дэмжиж байгаагийн хувьд бол орон нутагт анх удаа эрх барьж байгаа намын нэгжийн хууль дээр орон нутагт эрх мэдлийг төсвийн эрх мэдэлтэй, эдийн засгийн эрх мэдэлтэй нь хамт бас өгч байгаад нь бас их талархалтай байгаа. Тухайлбал энэ хуулиар үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар, газрын төлбөр, аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тодорхой хувь гээд орон нутагтаа үлддэг болж байгаа нь одоо маш давуу талтай гэж ингэж үзэж байгаа.

Дэмжихгүй байгаа асуудал бол энэ орон нутагт улс төржилтийг багасгая гэж байгаа бол орон нутагт 20 гаруй жил ажилласан хүний хувьд бол харж байгаа зүйл бол энэ баг хорооны анхан шатны нэгж баг, хорооны засаг даргыг дээд шатны сум, дүүргийн засаг даргад томилчихдог байвал орон нутагт улс төржилтийг багасгах маш том алхам болох гээд байгаа юм даа. Үүнийг л хийж чадсангүй дээ. Уг нь үүнийг хийчихсэн байсан бол саяхан одоо та бүхэн Баянгол дүүргийн иргэдийн нийтийн хурлыг харж байгаа байх. Ямар ч зохион байгуулалтгүй, харанхуй үдшээр ингээд нэг зааланд өөрсдийнхөө хүрээллийн хэдэн улсуудыг цуглуулж байгаад л ингээд хурал хийчхэж байх жишээтэй.

Тийм учраас энэ бол зөвхөн Баянгол дээр биш, Баянзүрх дээр ч 2016 онд гарч байсан. Тэгээд сумдууд дээр мөн адилхан, баг дээр мөн адилхан ийм байдаг. Тийм учраас үнэхээр л одоо хуулийн шинэчлэл хийе гэж байгаа бол одоо амьдрал дээр байгаа асуудлыг шийдье гэж байгаа бол уг нь баг, хорооноосоо эхлээд энэ анхан шатны нэг засаг даргыг томилчихдог байсан бол маш том өөрчлөлт орох байсан. Энийг одоо бас хийж чадсангүй.

Нөгөө талаар энэ хорооны засаг даргын ажлын албыг нэг тодорхой бага ч гэсэн төсөвтэй болгох асуудал дээр бас ахиц гарсангүй гэж би хувьдаа үзэж байгаа юм. 20 мянган хүн амтай, 30 мянган хүн амтай хорооны засаг дарга нар.../хугацаа дуусав/.

Г.Занданшатар: Сандаг-Очир гишүүнд нэмэлт 1 минут.

Ц.Сандаг-Очир: Энэ хорооны засаг дарга нар өнөөдөр айл өрхөөрөө явъя гэж бодоход Улаанбаатар хотын хорооны засаг дарга маш хүнд. Уулаар тарсан. Тэнд явган явна гэдэг бол үнэхээр хүндрэлтэй, машин тэрэг байхгүй, бичиг цаасны асуудал ингээд маш хүндрэлтэй байгаа. Тийм учраас энэ хорооны ажлын албыг тодорхой хэмжээний төсөвтэй болгох асуудлыг бас энэ хуулиар олгоод өгчихсөн бол бас том дэвшил, өөрчлөлт гарах байсан юм гэдгийг хэлээд энэ дээр бас тодорхой тайлбар авъя.

Г.Занданшатар: Жамъянхорлоогийн Сүхбаатар дарга.

Ж.Сүхбаатар: Эрхэм гишүүн Сандаг-Очирын асуултад хариулъя. Тэгэхээр хорооны асуудал дээр бол бид нар дэвшил гаргасан гэж хэлж болно. Нэгдүгээрт хорооны чиг үүргийг тусгаарлан тогтоосон, хоёрдугаарт яг таны хэлдэг асуудлыг энэ 16.4-т байж байгаа. Баг, хорооны үйл ажиллагааны зардлыг харьяалах сум, дүүргийн төсөвт тусгайлан батална гэж оруулж өгч байгаа юм. Анх удаа ингэж хийж өгч байгаа юм.

Дээр нь энэ хороо хэсгийн зохион байгуулалттай байхыг баталгаажуулж өгсөн. Ингэснээр орон нутагт аравт гээд асуудал үүсэхээр юм байсан. Харин хороо бол нийслэлийн хэмжээнд хороо хэсгийн зохион байгуулалтыг ажлын дотоод ажлаа зохион байгуулах энэ зохион байгуулалтыг хүлээн зөвшөөрч ингэж өгснөөр энэ нэлээн дэвшил гарч байгаа. Энийг дээр нь Сандаг-Очир гишүүний хэлээд байгаа дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурал энэ хэсгийн хуваарийг хийнэ гэж байгаа юм. Хорооны иргэдийн нийтийн хурал биш, жишээ нь гэх мэтээр. Энэ хороогоо бол анхаарч байгаа. Би өөрөө нийслэлээс сонгогдсон гишүүн учраас, нийслэлийн амьдрал бол хороон дээр буцалж байдаг учраас. Энэ хуулийн төсөл дээр баг, хорооны асуудал бол муугүй тусгагдсан гэж үзэж байна.

Хоёрдугаар асуудал нь баг, хорооны засаг даргыг сум дүүргийн засаг дарга шууд томилох ёстой гэдэг бол энэ Үндсэн хуулиар хязгаарлагдсан зохицуулагдсан. Одоо хоёр туйл яваад байна шүү дээ. Зарим гишүүд маань харин ч одоо нөгөө дээд шатны засаг даргын санал болгож болдог гэдэг чинь бол бараг халдаад байна гэж байна. Та бол шууд дээрээс томилъё гэж. Тэгэхээр энэ нутгийн өөрөө удирдах ёсыг бүр үгүйсгэсэн асуудал болно гээд ингээд яригдаж байгаа юм. Тэгэхээр энэний огтлолцол дээр бид яасан бэ гэхээр одоогийнхоо Үндсэн хуулийнхаа юманд тааруулаад, харин сум дүүргийн засаг дарга маань баг, хорооны засаг даргынхаа хажуугаар одоо бас нэр дэвшүүлэх тэр цуглаан дээр нь бас саналаа оруулж болох эрхийг өгч байгаа юм. Одоотой харьцуулбал бид нэг алхаж байгаа юм. Үүний шүүмжлэл чинь ингээд хоёр талаас яваад байна шүү дээ. Шууд томилж болохгүй байгаа шалтгаан чинь Үндсэн хууль дээр байна аа. Иргэдийн нийтийн хурлаас нэр дэвшүүлж дээд шатны Засаг дарга.../хугацаа дуусав/.

Г.Занданшатар: Одоо эрхэм гишүүн Тогмидын Доржханд гишүүн.

Т.Доржханд: Баярлалаа. Энэ чухал заалтууд нь байхгүй байна шүү дээ. Одоо энэ Адьшаа гишүүний асуултад тодорхой хариулмаар байна шүү дээ. Нөгөө сумдад улс төржихгүй, талцахгүй байдлыг бий болгоно гэсэн чинь байхгүй байна. Тэгэхлээр энэ дээр тодорхой хариулт өгөөч ээ, сүхбаатар гишүүн ээ.

Өмнөх чуулганаар бол уг нь нэг тодорхой ярьсан даа. Тэгээд хамгийн чухал зүйл нь бол энэ сумдуудыг нэгтгэх асуудал байна. Орон нутгийг. Тэгээд нэгтгэнэ гэдэг нь ингээд хүчээр аваачиж нэгтгэж байгаа зүйл биш шүү дээ. Эдийн засгийн агуулгаар нь нэгтгэе ээ, тэнд бүс нутгийн бүсчилсэн хөгжлөөр нь, тэр бүсээр нь бол нэгтгэж болж байна аа, коридороор нэгтгэж болж байна аа, кластераар нэгтгэж болж байна аа, хот байгуулах байдлаар нэгтгэж болж байна аа гээд.

Тэгээд нэгтгэсэн. Бас ингээд төвлөрөл ингээд саарсан тохиолдлууд зөндөө байдаг юм байна лээ шүү дээ. Одоо 1990-2000 оны хувьд бол Улаанбаатараас асар их олон хүмүүс ингээд гарч явсан. Яагаад гэвэл эдийн засаг энд хүндэрсэн, болохлоор.

Гэтэл эсрэгээрээ одоо ингээд бүгдээрээ Улаанбаатар хотдоо шавчихсан. Тэгээд 330 сумынх нь 50 хувь нь 2 мянга хүрэхгүй ийм хүн амтай, амьдрах боломж байхгүй. Тэгээд ямар ч бизнес, зах зээлийн орчин байхгүй. Ганцхан санхүүждэг газар нь бол төсөв болчихсон. Тэгээд ийм болохлоор энэ асуудлыг чинь шийдье гээд ингээд орж ирсэн шүү дээ. Тэгээд тэр нэг дэх асуудал маань хаана байна аа? Ажлын хэсгийнхнээс асуумаар байна.

Хоёрдугаарт үүнийгээ ард түмнээрээ хэлэлцүүлэхгүй юм уу? Ард түмнээрээ ер нь хэлэлцүүлсэн юм уу? Асуулт байна. Хуульчид ярихдаа энэ бол Үндсэн хуулийн дараагийн хэмжээний ийм үндсэн хууль юм аа. Бусад хууль бол энэ захирагдаж явахаас биш, энэ хууль бол бусад хууль нь захирагдаж явахгүй юм аа гээд тайлбарлаж байгаа юм. Маш том хууль байна аа. Үгүй ээ, тийм юм бол яагаад ард түмнээсээ асуухгүй байгаа юм бэ? Яагаад ард түмнийхээ өмнөөс хайр зарлаад тэр хүмүүс бол ингээд нүүдлийн соёлтой тэндээ байж байвал. . ./хугацаа дуусав/.

Г.Занданшатар: Доржханд гишүүн нэмэлт 1 минут.

Т.Доржханд: улс орны тусгаар тогтнолыг хангах ёстой юм гэсэн байдлаар ингээд хаагаад байгаа юм бэ? Одоо би ингээд Ганзориг докторoос асуумаар байгаа юм. Хүний эрхийн асуудал яах юм бэ? Одоо ингээд Сүхбаатар аймгийн нэлээн олон сумдууд, Дорноговийн олон сумдууд, ингээд усны асуудалтай байна шүү дээ. Гэтэл тэрийг чинь ингээд судалгаагаар маш муу устай байна аа гээд хүн амьдрахын аргагүй байхад заавал тэндээ амьдар гээд. Говь-Алтай аймагт, тухайлбал ингээд уулын орой дээр хүмүүс ингээд өрж байгаад жорлон нь хийж байна шүү дээ. Гэтэл тэндээ л байж байх ёстой. Яагаад гэвэл бид нар нүүдлийн соёлтой байдаг. Гүй ээ энэ хүний эрхийн асуудал яах юм бэ, тэгээд хүмүүсээсээ асуухгүй юм уу. Тэгээд энэ шинэчлэлээ зоригтой хийхгүй юм уу? Ийм болохлоор энэ асуудал дээрээ та нар ингээд байр сууриа гаргаж байгаад ард түмнээсээ асууж байгаад хамтдаа шийдье л дээ. Ингэж хөгжихгүй бол энэ хөгжих ямар ч боломжгүй байна шүү дээ. Төсөв чинь одоо ямар ч боломж байхгүй. Хөгжлийг санхүүжүүлэх ямар ч эх үүсвэр байхгүй, бүгдийг нь далан зургаа тийшээ тараачихдаг. Битүү улс төржилт. Өөрсдөө л гарч дарга болохоо чухал гээд байгаа болохоос тэр хүмүүсийн амьдрал, чанарын асуудлыг яах юм бэ. Тэгээд ийм болохлоор үүнийгээ эр зоригтойгоор шийдэцгээе л дээ.

Г.Занданшатар: Жамъянхорлоогийн Сүхбаатар дарга.

Ж.Сүхбаатар: Эрхэм гишүүн Доржхандын асуултад хариулъя. Яг таны яриад байгааг Улсын Их Хурал дахь олонхын бүлэг хийж байгаа. Би яг энэ ажлын хэсгийн хувьд хэлье. Ажлын хэсэг бол сая таны хэлдэг намын нэр дэвшүүлэх асуудал дээр бол Улсын Их Хурал дахь олонх цөөнхийн бүлгийн одоо тэр улс

төрийн намын шинэчлэл явуулах дараагийн тань том ажил байгаа. Үүнийг энд одоо татаж ирж нэгжийн хуулийн маргаанд татаж оруулмаар байна. Энэ өөрөө зөвхөн энэ асуудлыг ярих юм бол нэгжийн хуулийн асуудал хэлэлцэгдэх асуудал нь хоёрдугаар асуудал болчихно. Тийм л юм ажлын хэсэг баримталсан. Тийм учраас бид эхний алхам болгож суманд намын бүлэг байгуулахгүй гэсэн.

Хоёрдугаарх юм. Энэ засаг захиргаа, нутаг дэвсгэр нэгжийн удирдлагын хуулийн шинээр хийж байгаа цоо шинэ концепц бол боломж олгоно гэдэг юм байгаа. Яг таны сая хэлдэг. Энэ нэгжүүдийг томсгох, нэгтгэх тэр боломж процедурууд энд суучихсан байгаа. Анх удаа энэ процедур суусан шүү. Хуучин бол одоо Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлт дээр бид нар бас нэг иргэдийн саналаас гадна тухайн нутгийн хурлын саналыг авна гэсэн. Энийг өнгөрсөн жил бид бодлогоор Үндсэн хуулиар өөрчилж энэ цоожийн нэг цоожийг нь тайлсан. Одоо бид энийг боломжийг нь энэ нэгдэх ажлыг чинь Засгийн газар хийнэ. Хийхдээ ийм юмыг харгалзана, Улсын Их Хурал шийдвэрлэнэ. Тэгээд энэ дотор харгалзах үндэслэл дотор нь бид нар одоо саад болж болох зүйлийг нь авч хаясан.

Дээр нь энэ нэгжийг өөрчлөх асуудлыг санаачлахдаа өмнө нь иргэдэд үзүүлж байсан үйлчилгээг дордуулахгүй байх зарчим одоо оруулна гэдгийг дордуулахгүй байх зарчмын баримтална гэдгийг зааж өгсөн байгаа. Тэгэхээр таны хэлээд байгаа энэ яриад байгаа зүйлийг, энэ нэгжийн хууль батлагдчих юм бол энэ асуудал бол ингээд боломж нь онгойж байгаа юм. Түүнээс энэ хуулиар одоо тэр аймгийг ингэж нэгтгэ тэг гэдэг асуудал шийдэгдэхгүй. Энэ чинь Засгийн газар судалгаа тооцоогоо хийгээд Улсын Их Хуралд тусгайлан хэлэлцэж шийдвэрлэнэ. Та Засгийн газарт саналаа тавьж болно. Энэ боломжуудыг чинь урьд нь хүнд байсан бол зөөлөн болгож энэ журмыг нь хялбаршуулж байгаа юм аа. Харин ч зарим хүн шүүмжилж байгаа. Ийм одоо зүйл рүү та нар халтирч орох гэж байна уу гэдэг шүүмжлэл байгаа.

Г.Занданшатар: Энэ Үндсэн хуулийн 58.1-ийг тодруулж, энэ засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хуулиар орон нутагт эдийн засгийн боломж олгоход чиглэгдэж байгаа юм. Төвлөрлийг сааруулахад. Өөрөөр хэлбэл механикаар биш одоо орон нутаг үр ашиггүй байна гээд байдаг. Тэгтэл орон нутагт эрх мэдэл, орон нутгийн иргэдийн төлөөлөгчдийн хуралд эдийн засгийн асуудлыг шийдвэрлэх, татвар тогтоох өмчийн удирдлагыг хэрэгжүүлэх эрх мэдлүүдийг өгч байж тэр корпорац болж корпоративны хэлбэртэй болж байж. Нөгөө хуучин сум нэгдэл гэдэг шиг сумууд, аймгууд өөрөө бие даан төсвөө бүрдүүлэх, орон нутгийнхаа иргэдийн нийгмийн болон эдийн засгийн асуудлуудыг шийдэх эрх хэмжээг нь өгч байж ч дэлхийн нийтийн жишиг тийм юм байна лээ. Тэгэхгүй механикаар юу ч өгөөгүй. Эрх мэдэлгүй бүгдийг нь төвлөрсөн төсөвт төвлөрүүлээд авчихдаг, эргүүлээд хуваарилдаг. Энэ системээр бол социализмын үеийн энэ хуваарилалтын систем яваад байна.

Ийм учраас орон нутагт тэр татварын төсвийн тодорхой эрх мэдлүүдийг өгөөд өөр, өөрсдийгөө захиран зарцуулах өмчөө удирдах эрхийг нь өгч байж одоо газар нутгийн, нутаг дэвсгэрийн асуудлууд очиж, сумын иргэдийн төлөөлөгч,

аймгийн төлөөлөгч хурлууд нэгтгэх үү үү, яах вэ, эдийн засгийнхаа хувьд өөрөө нэгж болж хөгжихийг Үндсэн хуулийн 58.1 хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг бүхий засаг захиргаа, нутаг дэвсгэр нийгэм% эдийн засгийн цогцолбор мөн гэсэн үгийг бол Чимэд гуай корпорац гэдэг үгийг би цогцолбор гээд гадаад үг оруулахгүй гээд орчуулчихсан юм. Энэ бол субъект юм. Сүүлд нь Үндсэн хуулийн шинжилгээ ном дээр бол хуулийн этгээд байх ёстой юм гэж ярьж байсан.

Одоо бол энэ хуулийн үзэл санаа бол нийтийн эрх зүйн субъект болгож тодруулж байгаа юм. Ингэхээрээ, өөрөө өөрөө бие даан хөгжих, тэгээд детройт энэ тэр өөрсдөө дампуурч байсан, хэрвээ ингээд корпорацын хэлбэрээр явж чадахгүй бол өөрөө дампуураад байгаа, аяндаа нэгтгэгдээд, ингээд зах зээлийн жамаараа шийддэг энэ боломжийг энэ хуулиар олгож байгаа ийм үндсэн үзэл баримтлал нь энэ дээр тулгуурлаж хийж байгаа юм. Тэгэхгүй бол одоо иргэдийн төлөөлөгчдийн хурал бол хийх эрх хэмжээ байхгүй учраас ганцхан засаг даргаа л огцруулах асуудлыг хэлэлцдэг. Тийм болчхоод дандаа засаг даргаар оролдож байдаг, ийм институц болчхоод байдаг учраас.

Хүний эрхийн асуудлаар Ганзориг доктор 84 дээр.

Д.Ганзориг: Хоёр асуудал байна гэж ойлголоо. Нэгдүгээрт нь бол юу вэ гэхээр засаг дарга, нутаг дэвсгэрийн нэгжийн хуваарийг өөрчлөх асуудал дээр ер нь ямар шинэ хандлага байгаа юм бэ гэдэг ийм зүйл. Тэр тусмаа энэ өөрчлөх асуудлыг шийдвэрлэхдээ тухайн нутагт оршин сууж байгаа иргэдийн саналыг яаж авах вэ, тэр санал өөрөө хэрхэн яаж тусгагдах юм гэдэг ийм хүсэл зоригийн илэрхийллийн асуудал байна гэж. Тэгэхээр бид бас энэ дээр, ер нь гучаад жил энэ асуудалд бол тэр болгон сайн орж чадаагүй л байсан ийм асуудал мөн үү гэвэл мөн. Гэхдээ энэ асуудалд бол нэлээн прагматик хандах ёстой байх гэж.

Яагаад гэхлээр 20, 30-аап жилийн хугацаанд тодорхой нэг нэгжийг өөрчлөх, татан буулгах, нэгтгэх асуудал гарахад ихэнх тохиолдолд иргэдийн санал нь өөр өөр гардаг юм байна. Тэгээд энэ тохиолдолд Үндсэн хуулийнхаа 58.3 гэсэн энэ иргэдийн саналыг үндэслэнэ гэдэг энэ үгийг юу гэж ойлгох юм бэ гэдэг дээр л бид гацаанд ороод ингээд Үндсэн хуулийн цэц дээр очиж асуудал үүсдэг, ийм зүйл мөн. Тийм учраас энэ дээр бид үүнээс аль болохоор зайлсхийхийн тулд төслийн 13.3 гэсэн энэ заалтыг бол нэгдүгээрт оруулсан,

Хоёрдугаарт тодорхой нутаг дэвсгэрт оршин сууж байгаа иргэдийн хүний эрхийн асуудал гэж. Энэ тодорхой нутаг дэвсгэрт оршин сууж байгаа хүмүүсийн хүний эрхийн асуудал гэхээс илүү энэ бол Монгол улсын нийт оршин суугчдын хүний эрхийн асуудлыг, хүний эрхийг хамгаалах асуудлыг хүлээдэг үүрэг нь бол өөрөө төр өөрөө мөн. Тэгэхээр энэ хүрээндээ хийх ажлууд, жишээлбэл тодорхой асуудал дээр унд усны асуудал гэдэг дээр бид өнөөдрийн удаад юу гэж шийдэж байгаа вэ гэхээр унд усныхаа асуудал ямар худагтай байх. Хүн гэдэг энэ асуудлаар хамгийн ойрхон нэгж болох сум өөрөө нэгдүгээрт шийд ээ. Гэхдээ тэрэнд тусалж дэмжих үүрэг нь бол улсын үүрэг шүү гэдэг ийм байдлаар л хийж байгаа юм. Өөрөөр хэлэх юм бол хөрөнгө мөнгөний хувьд, зохион байгуулалтын хувьд, хүний нөөцийн хувьд улс дэмжих тухай асуудал энэ дээр байна. Гэхдээ

нэгэнт тухайн асуудлыг өөрсдөө мэдэрдэг учраас мэддэг учраас энэ хаанаа яаж зохион байгуулах вэ гэдэг бол энэ сумын өөрийнх нь орон нутгийн чиг үүрэг шүү гэдэг. Ийм байдлаар л бид нар энэ хуульд хандаж ингэж хийсэн юм байгаа юм.

Г.Занданшатар: Жанжин Д.Сүхбаатарын танхимаас Хассуурийн Ганхуяг гишүүн асуулт асууна.

Х.Ганхуяг: Сайн байцгаана уу? Энэ өдрийн мэндийг хүргэе. Энэ хуулийг бол дэмжиж байгаа. Гэхдээ бид нар бас яг энэ сүүлийн өнгөрсөн гучин жилийн алдаа оноогоо дүгнээд үзэхээр энэ 28.1 дүгээр зүйл дээр бол яах аргагүй бид нар ярилцах ёстой юм аа. Яагаад вэ гэхээр орон нутгийн төсвийн суурь зарлагыг улсын төсвөөс олгох орлогын шилжүүлэг улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг буюу татаасыг хэлээд байгаа юм л даа. Бид нар одоо орон нутагт бол төсвийн болон эдийн засгийн мөн өөрөө удирдах нэлээн том эрх мэдлүүдийг олгох гэж байгаа юм. Тэгээд энэ бол зөв юм байгаа юм.

Гэхдээ эргээгээд энэ төсвөө өөрөө авч явдаг тэр тогтолцоог нь бид нар бүрдүүлэх ёстой юм л даа. Улсын төсвөөс татаас өгдгийг зогсоомоор байгаа юм. Бүр онцгой тохиолдолд Улсын Их Хурлаар хэлэлцүүлж байж өгдөг болгох хэрэгтэй. Тэгэхгүй бол энэ орон нутаг хэзээ ч бие даахгүй. Тэгэхгүй бол энэ орон нутгийн засаг дарга нар, багийн дарга нар ланд 200 авч унадаг асуудал хэзээ ч таслан зогсоогдохгүй. Мөнгөгүй байж байж төсөв нь хэцүү юм мөртөө өнөөдөр ланд 200 зуу аваад л унаад л явж байна шүү дээ. Татаасыг зогсоож байж орон нутгууд сайн дурааараа хүн ам амьдардаггүй бага хүн амтай багуудаа нэгтгэх, хэрэггүй орон тоогоо цөөлөх ийм үйл ажиллагаа явагдаж эхэлнэ шүү дээ. Тэгээд бид нар бол ингээд зөвхөн эрх зүйн талаас нь, орон нутгийн талаас нь, сонгуулийн талаас нь бодолцоод энэ хуулийг ингээд ярилцаад яваад байна л даа.

Тэгээд одоо 15.1.16-аар концесс болон үнэт цаас гаргах эрхийг нь ингээд орон нутагт олгох гэж байна л даа. Тэгээд яах вэ энэ дээр бол Сангийн сайд вето тавих эрхтэй гэж байгаа юм. Тэгэхээр энэ чинь одоо юу гэсэн үг вэ гэхээр лобби сайтай орон нутаг бол өр тавиад л дуртай юмаа хийчихнэ. Тэгээд дараад нь мөнгөгүй боллоо гээд улсын төсвөөс энэ мөнгөө төлүүлдэг ийм л юм руу явах гээд байна шүү дээ. Тэгээд энэ дээр хариуцлагын юм ерөөсөө юу ч байхгүй.

Т.Аюурсайхан: Ганхуяг гишүүнд минут өгье.

Х.Ганхуяг: Тэгээд энэ аймаг орон нутаг баг, сум, одоо эд нар чинь ингээд өрөнд ороод мөнгөө төлж дийлэхгүй болчихвол хэн хариуцлага хүлээх вэ гэдэг юм чинь юу ч алга байна шүү дээ энэ дээр. Тэгээд ингээд татвар төлөгчдийн нуруун дээр энэ нэг баахан хоёр зуу авахуулдаг, баахан сонгуулийн амлалтаар сонгуульд ажилласан хүмүүсийг ажлын байраар хангадаг, хэрэгтэй, хэрэггүй орон тоо бүтцээ данхайлгадаг энэ юм чинь арилахгүй шүү дээ. Тэгээд бид нар бас хариуцлагын юм нэгдүгээрт алга байна. Хоёрдугаарт улсын төсвөөс олгох энэ татаасыг бол энэ 58.1 дээр байгаа зүйл заалтаа бид нар засмаар байна аа. Үүнийг онцгой тохиолдолд Улсын Их Хурлаар, Төсвийн байнгын хороогоор орж хэлэлцдэг тийм горим руугаа явах ёстой шүү дээ. Бид нар хариуцлагаа

өндөржүүлмээр байна. Энэ дээр та бүхэн надад нэг хариулт өгөөч ээ.

Т.Аюурсайхан: Сүхбаатар гишүүн хариулъя.

Ж.Сүхбаатар: Эрхэм гишүүн Ганхуягийн асуултад хариулъя. Энэ орон нутаг татаасгүй бие дааж хөгжих тухай асуудал ярьж байна аа, зөв өө. Ер нь бол орон нутаг бие даах гол нөхцөл нь төсөв санхүү, эдийн засаг аж ахуйн хувьд биеэ даасан байх тухай асуудал байгаа. Бид нар бас захиргааны эрх мэдлийг шилжүүлж захиргааны бие даасан байдлыг хангах асуудлыг анхаарч байгаа. Гэхдээ энэ хуулийн яг энэ концепц бол таны хэлдэг энэ чиглэл рүү байгаа. Юу юм бэ гэхээр бид нар улсын төсвөөс бүгд хараат байна. Одоо манай энэ жилийн төсөв дээр харах юм бол нийслэл Улаанбаатар хот, бусад таван аймаг байгаа. Зургаан ийм засаг захиргааны том нэгж биеэ дааж байгаа, татаасгүй ажиллаж амьдарч байна гэсэн үг. Бусад нь татаастай. Ер нь бол бусад улсыг харьцуулах юм бол Герман ч гэсэн 3 муж улс нь л үндсэндээ бусдыгаа тэжээдэг шүү дээ. 16 гол том нэгжтэй гэхэд. Тэр утгаараа бусад улс оронтой харьцуулахад манай улсын юм бол дундаж орчимд явдаг.

Яг судалгаагаар аваад үзэх юм бол манай орон нутгийн төсвийн бааз суурь их сул. Энэ хуулиар бид нар бүр зоригтой сум, дүүргийн татварын орлого дээр хамгийн тогтвортой байдлыг ямар орлогыг шилжүүлэх вэ гэхээр газрын төлбөр, үл хөдлөх хөрөнгийн татвар, тэгээд хүн амын орлогын албан татварыг аймаг, нийслэлд биш сум, дүүрэг рүү өгчхөж байгаа юм. Ингэснээр юу болж байна вэ. Ингэснээр сум дүүргийн авдаг татаас шилжүүлэг цаад утгаараа ингэж тогтвортой орлого шилжүүлчхэж байгаа учраас татаас шилжүүлэг зогсоно. Дээр нь энэ орлогыг хураах, бизнесийн идэвхжилийг тэнд дэмжих сонирхол бий болж байгаа юм. Энэ бол анх удаа хийгдэж байгаа том реформын ийм алхам болж байгаа.

Дээр нь бас аймаг, нийслэлд бид нар аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 40 хувийг шилжүүлнэ гэж байгаа. Мэдээж зарим төсөв, татварын онцлог, нийгэм эдийн засгийн амьдралтай холбогдуулаад түрүүний бид нарын хэлдэг нөгөө хуулийн онцлог зохицуулалтыг зарим газар хийх шаардлага бий бусад хуулиараа.

Т.Аюурсайхан: Одоо Лувсанцэрэнгийн Энх-Амгалан Байнгын хорооны дарга нэмж хариулъя.

Л.Энх-Амгалан: Ганхуяг гишүүн ээ, Доржханд гишүүн хэлээд байгаа санаа нь их зөв байгаа даа. Тэгээд хөдөөгийн сумдуудыг яаж бие дааж амьдруулах вэ, эдийн засгийн ямар хөшүүргүүдийг бий болгох вэ гээд их зөв л дөө. Тэгэхдээ бид нар бас нэг жаахан хөрсөн дээрээ бууж, амьдрал бас ойлгох ёстой. Одоо жишээ нь саяын судалгаагаар 21 аймгийн чинь 6-хан аймаг нь төсвийн татаасгүйгээр амьдарч байна шүү дээ. 330 сумын бараг 20 хүрэхгүй сум нь өөрийнхөө орлогыг бүрдүүлж амьдардаг ийм л сумууд байгаад байгаа юм. Тэгэхээр юу юугүй одоо ингээд сумдуудын төсвийг одоо энэ чинь бараг үндсэндээ 330 суманд амьдарч байгаа иргэдээ бид нар та нарын хохь гээд хаяж болохгүй л дээ. 330 сумын төсвийг одоо бид нар татаад өгөх, өгөхгүй тухай асуудлыг Улсын Их Хурал дээр

татаж авчирна гэдэг бол бүүр их төвлөрсөн эрх мэдлийг төвлөрүүлж байгаа асуудал байгаа юм. Тэгэхээр бид нарын энэ нэгжийн тухай хууль, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн.../хугацаа дуусав/.

Т.Аюурсайхан: Энх-Амгалан даргад нэг минут нэмж өгье.

Л.Энх-Амгалан: Засаг захиргаа нь нутаг дэвсгэрийн нэгжийн энэ хуулийн амин сүнс нь ерөөсөө тухайн баг, сумдад, дүүргүүдэд одоо ингээд тодорхой эдийн засгийн эрх мэдэл өгч байгаа. Энэ бол сая Сүхбаатар ажлын хэсгийн ахлагчийн тайлбарласан татварын эрх мэдлүүд. Одоо хамгийн наад захын жишээ гэхэд би энэ жил улсын төсөв батлагдахад хамт батлагдсан малын хуулийн татвар бий болж байгаа юм. Тэгэхэд одоо бараг үндсэндээ 60-70-аад тэрбум төгрөгийн энэ боломжууд нь орон нутагтаа үлдэх ийм боломжууд гарч ирж байна гэж байна шүү дээ. Бид нар өнөөдөр хаана худаг ус гаргахыг Их Хурал дээр ирээд суугаад байж болохгүй л дээ. Хаана сургууль засах юм, дээвэр, цонх засахыг Их Хурал дээр яриад сууж болохгүй. Тийм учраас ямар ч байсан энэ нэгжийн тухай хууль ингээд батлагдаад амьдралаар шалгагдаад ирэхэд бол орон нутаг маань өөрсдөө төсвөө бүрдүүлэх, өөрсдөө татвараа тогтоох, энэ эдийн засгийн хөшүүрэг, эдийн засгийн идэвх сонирхлууд нь бас бид бодитойгоор бий болгох ийм алхмууд бол хийгдэх байх гэж бодож байгаа юм.

Т.Аюурсайхан: Одоо Жамбалын Ганбаатар гишүүн асуулт асууна, үг хэлнэ.

Ж.Ганбаатар: Баярлалаа. Би ер нь Сандаг-Очир гишүүн, Ганхуяг гишүүн хоёртой бол зарим зүйл дээр бол санал нэг байна. Ер нь бид нарын гаргаж байгаа хуулиудад уяж байгаа хариуцлагын тогтолцоо их сул аа. болохгүй л гээд л орхичихдог. Тэгээд тэр хуулиа зөрчвөл яах юм бэ гэдэг асуудал их сул. Одоо хурлаа зарлахгүй бол яах юм бэ гэдэг асуудал хүртэл сая яг амьдрал дээр тохиолдсон шүү дээ. Зарлана аа гээд л заачихсан болохоос биш зарлахгүй бол яах вэ гэдэг асуудал. Би ажлын хэсэг болоод хэлэлцэх нэгдүгээр хэлэлцүүлэг дээр тодорхой саналуудаа хэлчихсэн учраас ер нь хууль бол нэлээн шинэлэг.

Ялангуяа орон нутагт бол нэлээн эрх мэдлийг өгсөн. Би энийг бол сайн гэж харж байгаа юм. Орон нутгийн удирдлага санаачлагатай ажиллах ёстой. Сая Энх-Амгалан даргын хэлж байгаа шиг одоо бүх зүйлээ дээшээ хараад суугаад байж болохгүй л дээ. Өөрсдөө санаачлахтай хуулийн дагуу тэгж ажиллах ёстой. Асуулт байгаа нь болохлоор тэр аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 40 хувь, сая Сүхбаатар дарга хэлэхдээ нийслэл, аймаг гээд хэлчихлээ. Дүүрэгт аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 40 хувь гэж одоо би бол тэгж ойлгосон.
Яг энэ тэгээд тэрүүгээрээ байна уу?

Хоёр дахь асуулт нь бол аж ахуйн нэгжүүдийг нийслэл улсын татвар татаад авчихдаг шүү. Уул нь бол хэн хаанаас одоо эх үүсвэр авч байна, тэндээ татвараа төлөх ёстой, энэ зарчим шүү дээ. Гэтэл зүгээр нэг жоохон томронгуут л нь одоо төв татвар гэдэг юм уу, нийслэл татаад авчих. Тэгвэл одоо нөгөө аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 40 хувь гэдэг чинь зүгээр нэг хэлбэрийн төдий нэг тийм зүйл болж хувирна шүү. Энэ талаар одоо тодорхой хариултыг өгөөч гэж

хэлье. Тэр хариуцлагын тогтолцоо гэдгийг Сүхбаатар ажлын хэсгийн ахлагч гишүүн, уг нь бол нэлээн сайн . . ./хугацаа дуусав/.

Г.Занданшатар: Сүхбаатар гишүүн хариулъя.

Ж.Сүхбаатар: Эрхэм гишүүн Ганбаатарын асуултад хариулъя. Энэ аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 40 хувь гэдэг бол бид нар бас0 зоригтой энэ асуудлыг ярьж судалж байгаад ингээд энэ чинь улсын төсөвт ордог орлого. Тэгээд энийг бол аймаг нийслэл рүү шилжүүлж өгч байгаа юм. Дээр нь аймаг, нийслэлд явж байгаа хүн амын орлогын албан татварыг чинь бид нар сум, дүүрэг рүү өгчхөж байгаа байх. Хүн амын орлогын албан татвар чинь хамгийн одоо тогтвортой орлого шүү дээ. Хүн амын орлогын албан татвар чинь. Дээр нь бид нар энэ газрын төлбөрийг 60, 40 гэж нийслэл, дүүрэг хуваадаг байсныг нь 100 хувь дүүрэг рүү шилжүүлчхэж байгаа юм. Тэгээд үл хөд хөрөнгийн татварыг бас тийшээ өгчхөж байгаа юм, дүүрэг рүү.

Тэгэхээр чинь нийслэлийн одоо хамгийн гол суурь орлого болсон орлогын гол хэсгийг бид нар үндсэндээ дүүрэг рүү шилжүүлчхэж байгаа юм. Одоо улсын хэмжээнд чинь нэг өнгөрсөн жилээр тооцоход 800 гаруй тэрбум төгрөг гэхэд хувь хүний орлогын албан татвар дээр явж байсан байх. Дээр нь үл хөдлөх хөрөнгийн татвар гэхэд бараг 100 орчим тэрбум төгрөг байсан. Газрын төлбөр гэхэд 70 гаруй тэрбум төгрөг явж байсан санагдаж байна. Ингээд үзэхээр 1 их наяд төгрөгийн орлогын бааз суурь чинь сум, дүүрэг рүү шилжчихэж байгаа юм.

Тэгэхээр чинь тэр аймаг нийслэл чинь тэрнийхээ оронд юу авах ёстой юм бэ гэхээр аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг улс одоо авах биш, тэнд бас байж байгаа аж ахуйн нэгжийнхээ орлогыг өөр дээрээ авах ёстой. Тэгэхдээ энэ дээр мэдээж тус тусдаа татвар, төсвийн асуудал дээр зохицуулалтууд гарч таарах юм байгаа юм. Энэ дээр мэдээж бас Сангийн яам, Засгийн газрын зүгээс хэр яаж хандах юм байгаа юм. Бодлого бол ингэж явах ёстой. Улсын Их Хурал ингэж л үзэх ёстой. Судалгаа тооцоонууд хийгдсэн юм бол ийм байгаа.

Харин дүүргүүд бол энэ дээр маш их боломж нь дээшилж байгаа шүү дээ. Ямар ч гэсэн энэ дүүргүүдийн тооцоон дээр, жишээлбэл Багануур дүүрэг дээр гээд ярихад Сандаг-Очир гишүүн бид хоёр ярьж л байсан. Нэгээс хоёр тэрбум төгрөгийн илүү орлого нь ороод ирэх боломж үүсчихэж л байгаа байхгүй юу. Татаад шилжүүлэх нь зогслоо гэж бодоход.

Т.Аюурсайхан: Ганбаатар гишүүнд нэг минут асуултаа тодруулъя.

Ж.Ганбаатар: Баярлалаа. Би сая ажлын хэсгийн гишүүдээс ч гэсэн асуулаа, тэгээд ойлголоо. Хариуцлагын тогтолцоон дээр Сүхбаатар гишүүн асуултад хариулж амжсангүй. Ер нь одоо бид юу гэж ойлгодог вэ гэхээр хууль дээр болохгүй гээд л биччихлээр, ерөөсөө л болохгүй гэж л ойлгох л улс төрчид бол нэвт байдаг л даа. Тэгэхдээ соёл байх. Энэ зөв соёл байх. Гэхдээ болохгүй гэдгийг зөрччихсөн тэр албан тушаалтныг яах вэ гэдэг асуудлыг одоо ойлгодог байгаач ээ л гэж байгаа шүү дээ. Зөвшөөрөхгүй гээд байхыг зөвшөөрнө өө гээд

зөрччихсөн тэр албан тушаалтныг яах вэ л гэдэг асуудал байхгүй юу. Үүнийгээ, ингээд зүгээр нэг ганцхан Зөрчлийн тухай хуультай ч юм уу, ингээд холбоод орхичихдог бол тэгээд тэр чинь нэг хэлбэр болчхоод байна шүү дээ. Үүнийг яг одоо ойлгож ажилладаг байгаасай л гэж одоо хүсэж байгаа шүү дээ. Санал хэллээ.

Г.Занданшатар: Одоо эрхэм гишүүн Цэрэнжамцын Мөнхцэцэг.

Ц.Мөнхцэцэг: Энэ Засаг захиргааны хуулийн төсөл дээр анх ажлын хэсгийн өргөн барьсан анхны үзэл баримтлалаас нэлээд олон зүйл маань бас ингээд өөрчлөгдөөд явчихсан байна. Зарим нэг дэвшилттэй заалтууд маань хасагдсан байна. Тухайлбал энэ 34.2 дээр нийслэлийн иргэдийн төлөөлөчийн хурлыг дүүргийн иргэдийн хурлаас сонгож байгуулна гэсэн заалт явсан. Энэ яагаад хасагдсан бэ?

Ер нь Монгол улс 1992 онд орон нутгийн байгууллага доод шатны хурлуудаасаа дээд хурлын төлөөлөгчдөө сонгож ирсэн ийм уламжлал байсан. Энэ чиглэлийг хэрэгжүүлэх боломжтой. Аймаг, орон нутагт энэ улс төрчийг багасгахын тулд бид нар бас зарим сонгуулиас татгалзах нь уг нь бол зүйтэй байсан. Гэтэл энийг ингээд хасчихсан байна.

35.3-ыг бас түрүүн асуугаад зарим гишүүдийн асуултад тодорхой хариулт өгөхгүй байна л даа. Энэ сумын иргэдийн хуралд улс төрийн нам нэр дэвшүүлж оролцохгүй гэсэн энэ заалтаа яагаад хасчихсан юм бэ? Ер нь хүн ам цөөтэй сумуудад энэ улс төрийн нам үйл ажиллагаа явуулах, тэгээд дээрээс нь сонгуульд оролцоно гэдэг маш их улс төржилтийг бий болгодог. Энэ уг нь дэвшилтэй заалт байсан юм. Энийг яагаад хасчихсан бэ?

Мөн 41.3 дээр маш их сайн заалт байсан юм, бас хасчихсан байна л даа. Хурлын төлөөлөгчийн эрх үүргээ хэрэгжүүлэх үйл ажиллагаанд улс төрийн нам бусад байгууллага, албан тушаалтан оролцох нөлөөлөхийг хориглоно гэсэн, энэ заалт маань бас хасагдсан байх юм. Тэгэхээр үүнийг ингээд хасчихсан гэдэг маань одоо нөгөө улс төрийн нам болон бусад байгууллагууд энэ орон нутгийн хуралд одоо нөлөөлнө гэсэн үг үү?

Энэ хуулийн дагалдаж байгаа Төсвийн тухай хуулийн 58.1 дээр энэ Ганхуяг гишүүн, Ганбаатар гишүүн нартай санал нэг байна. Тэртээ тэргүй аймаг орон нутагт татварын болон газрын төлбөрийн эрхийг олгож байгаа юм чинь давхар хариуцлагын зарчмыг сайн суулгаж өгмөөр байна. Энэ нь одоо хаа байна аа?

Г.Занданшатар: Мөнхцэцэг гишүүнд нэмэлт 1 минут.

Ц.Мөнхцэцэг: Энэ 58.7, 58.8 дээр түрүүн бас зарим гишүүд асуугаад байсан. Энэ дээд шатны засаг дарга нь одоо тухайн доод шатны засаг даргыг томилохдоо татгалзаж болно гээд. Тэнд хуулийн болон бас үндэслэл заахгүйгээр. Тэгэнгүүтээ 58.8 дээр нэг л удаа ингээд татгалзчихсан бол хурлаас одоо өөр нэр дэвшигчийг явуулна гэчихсэн байна. Тэгэхээр энэ маань одоо ерөөсөө нэг удаа

нэр дэвшээд л дээд шатнаас татгалзах юм бол тухайн хүн бол орон нутагт улс төрийн дахиад өөр албан тушаал томилогдох боломжгүй болгочхож байгаа юм уу? Энэ нь бас эрх зүйн хувьдаа ч гэсэн одоо субьектив шинжтэй заалт байгаад байна. Энэ дээр одоо ямар учраас ингэж оруулсан бэ?

Г.Занданшатар: Жамъянхорлоогийн Сүхбаатар ажлын хэсгийн дарга.

Ж.Сүхбаатар: Эрхэм гишүүн Мөнхцэцэгийн асуултад хариулъя. Тэр улс төрийн бодлоготой холбоотой шийдлүүд гарсан л даа. Ер нь улс төрийн бодлоготой холбоотой зарим заалтуудын асуудлууд, ажлын хэсэг шийдсэн юм биш л дээ, Мөнхцэцэг гишүүн ээ. Бид бол томьёолол хийсэн хүмүүс. Яг түүн дээр бол. Өөрөөр хэлбэл та бид чинь Улсын Их Хурал дахь олонхын бүлэг дээр Их Хурлын бүтцийн байгууллага шүү дээ. Яриад байгаа асуудлуудаар шийдвэр гарчихсан байхгүй юу. Тэгэхээр ажлын хэсэг гэдэг чинь санаанаасаа зохиодоггүй өөрсдөө мэргэжлийн хүмүүсийн судалгаа дүгнэлт дээр үндэслэж юмаа хийхээсээ гадна Улсын Их Хурал дахь бүтцийн олонхын бүлгийн бодлого, байр суурийг чинь бас нэг томьёололд оруулж байгаа юм гэсэн үг. Тийм. Тэр нам нэр дэвшүүлэх эсэх асуудал дээр чинь бол тийм асуудал болсон гэж хэлмээр байна. Аль аль бүлгүүд нэг ийм асуудлаар ярилцаад шийдэгдсэн асуудал юм аа гэж.

Тэр хариуцлагын асуудал яриад байгаа юм аа. Хариуцлагын асуудал гэдэг дээр бол энэ чинь ийм шүү дээ. Хариуцлага энэ хуульд байхгүй гэж. Байгаа шүү дээ. Хурлыг татан буулгаад одоо хурал тодорхой хугацаанд хуралдахгүй төсвөө батлахгүй байгаад байх юм бол татан буулгана аа. Энэ хариуцлага мөн үү? Мөн. Өмнө нь байгаагүй энэ хурал. Баянзүрх дүүргийн хурал одоо хуралдахгүй, ингээд засаг даргаа тавьж чаддаггүй ч гэнэ үү? Ингээд яваад байсан. Энэ асуудлыг шийдсэн үү? Шийдсэн. Тогтолцооны хариуцлага гэж ярьж байгаа шүү дээ, үүнийг чинь бол, тогтолцооны. Дээр нь хурлаас гадна Засаг даргыг огцруулах, ажлыг нь үнэлж дүгнэх асуудал энэ хуульд байгаа юу? байгаа.

Дээд шатны засаг дарга буюу дээд шатны засаг даргыг Ерөнхий сайд ажлаа муу байсан гэж дүгнэх, хурал нь бас өөрөө ажлын тайланг сонсож үнэлж дүгнэх асуудлууд байна уу, байна. Дээр нь нутгийн өөрөө удирдах ёсыг хамгаалахын тулд нутгийн удирдлагын төлөөллийн мэргэжлийн ийм төлөөллийн холбоо шиг байгууллагыг байгуулж байгаа. Энэ бол хэрвээ эрх нь зөрчигдөх юм бол орон нутгийн эрхийг хамгаалж шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй. Засгийн газартай хэлэлцэх ёстой.

Г.Занданшатар: Мөнхцэцэг гишүүн 1 минут тодруулах уу.

Ц.Мөнхцэцэг: Энэ нөгөө төсвийн хариуцлагын тухай асуугаад байна л даа. Одоо ингээд тухайн аймаг орон нутаг, татаас авдаг аймгуудын хувьд, жишээлбэл, эсвэл төсөвт төвлөрүүлсэн орлогоо дутуу төвлөрүүлчихсэн бол нэг бол одоо төсвийн зардлаа хэтрүүлсэн өрөнд орсон тохиолдолд энэ засаг дарга байна уу, хуралд нь тооцох эдийн засгийн хариуцлага гэдэг юм уу, үүнийг яаж оруулсан юм бэ? Энэ бол харагдахгүй л байна л даа.

Г.Занданшатар: Жамъянхорлоогийн Сүхбаатар эрхэм гишүүн, ажлын хэсгийн дарга.

Ж.Сүхбаатар: Энэ төсвийн харилцааны асуудал бол Монгол Улсын төсвийн кодекс буюу төсвийн төрөлжсөн хуулиар зохицуулагддаг тусдаа харилцаа. Манай энд юу орж ирж байгаа юм гэхээр зэрэг орон нутгийн төсвийн одоо үндсэн гол асуудлууд л орж ирж байгаа юм. Тэрнээс төсвийн харилцааны эрх үүргийн хуваарилалт, төсвийн харилцаан дахь тодорхой төв засгийн газартайгаа харилцах гэдэг юм уу, хоорондоо байгууллагуудын харилцах асуудлууд бол Төсвийн тухай хуулиар зохицуулагдсан асуудал.

Ер нь энэ хууль бол гол нь боломж олгосон, засаг, захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн ерөнхий зохион байгуулалт, дүр зургийг ингэж харуулж байгаа ийм л хууль юм байгаа юм. Энэ хууль чинь одоо орон нутгийн бага Үндсэн хууль гээд байна шүү дээ. Тэгэхээр тэр таны яриад байгаа асуудал бол Төсвийн тухай хуулиар зохицуулалттай асуудлууд. Тэр татварын орлогоо яаж бүрдүүлж байгаа юм? Төсвийн орлого дээр дутагдлууд үүсвэл яах юм. Тэр хариуцлагагүй байдлууд үүсвэл яах юм. Энэ дотор манай энэ хуулийн чинь асуудлын гол зорилго нь зохицуулах харилцаа нь яг энэ асуудал бас биш л дээ. Бид нар хуулийн зохицуулах зүйл гээд харилцааны хэсгийг харах . . ./хугацаа дуусав/.

Г.Занданшатар: Эрхэм гишүүн Жамбын Батсуурь асуулт асууна.

Ж.Батсуурь: Энэ одоо Үндсэн хуулийн дараа орох Монгол Улсын тусгаар тогтнолын баталгаа болсон ийм том хууль хэлэлцэж байгаа. Тэгээд ажлын хэсэг, ажлын дэд хэсэг бол нэлээд сайн ажилласан. Миний энэ асуух асуулт бол Улсын Их Хурлын удирдлага буюу Төрийн байгуулалтын байнгын хорооноос асуумаар байгаа юм. Яагаад вэ гэхээр, энэ 56.1.5, 56.7, 56.8 гэдэг энэ заалтууд бол үндсэндээ Үндсэн хууль зөрчсөн ийм заалтууд орж ирж байгаа юм. Энэ яагаад вэ гэхлээр, 1996 онд Содовсүрэнгийн Нарангэрэл нарын хүмүүс Үндсэн хуулийн цэцэд хандаад, тэгээд яг одоо энэ зөвшилцөнө гэсэн заалт бол Үндсэн хууль зөрчсөн байна гэсэн ийм дүгнэлт гарч ирсэн.

Тэгэхлээр зөвшилцөнө гэснээс илүү санал болгоно гэдэг чинь бүх шатанд Монгол Улсын энэ хуулиар олгогдож байгаа бүх асуудлуудыг дагасан улс төрийн ийм бусармаг далд үйл явдал болж харагдаж байгаа юм. Тэгэхлээр үүнийг зогсоохгүй бол энэ одоо хэдий сайхан олон хүмүүсийн хөдөлмөрөөр чиг үүрэг, аймаг суманд олон сайхан зүйл очиж байгаа ч гэсэн энэ улс төр талаасаа бол энэ хуулийг үндсэнд нь амьгүй сүнсгүй болгож байна. Монгол Улсын тусгаар тогтнолыг алдагдах хэмжээнд одоо ийм асуудлууд орж ирж байна. Дан дангаар нь харах юм бол нэг их асуудал биш, одоо юу гэдэг юм буцааж болно. Дээд шатны засаг дарга. Тэгээд ямар ч хуулийн үндэслэлгүй буцаана гэдэг чинь одоо ер нь яана гэсэн үг юм бэ? Буцсан хүн дахиж нэр дэвшихгүй өөр хүн дэвшинэ. Ингээд энэ 3 заалтыг угсраагаар үзэх юм бол ерөөсөө Монгол Улсын тусгаар тогтнолд бол шууд хандаж халдаж байна гэсэн зүйл байгаа юм. Яагаад вэ гэхлээр, дунд, анхан шатанд очсон.../хугацаа дуусав/.

Г.Занданшатар: Батзориг гишүүн нэмэлт 1 минут.

Ж.Батсуурь: эдийн засгийн болон бусад эрх мэдлүүдийг яг дагасан улс төрийн эрх мэдэл очиж энэ босоо тогтолцоо үүсэх нь гэсэн энэ санааг хэлэх гэсэн юм. Ер нь энэ орон нутгийн тусгаар тогтнол, орон нутагтай холбоотой асуудал ярингуут би энэ Доржханд гишүүнд бас хандаж хэлмээр байна. Орон нутагт амьдрах нь байтугай, бараг очиж үзээгүй хүн энэ орон нутгийн асуудлаар юм ярьдгаа болих хэрэгтэй ерөөсөө. Өөрийнх нь амьдарч байсан, олон жил ажилласан гээд байгаа Улаанбаатар өнөөдөр ямар болчхоод байгаа юм. Түгжрэл энэ тийм одоо гайхалтай болчхоод байгаа юм уу. Тийм учраас орон нутгийн асуудал мэдэхгүй байж байж энэ орон нутгийн хууль дээр, энэ орон нутгийн тухай асуудлуудыг дордуулах санал хэлдэг, энэ талаар одоо асуудал ярьдгийг болих хэрэгтэй гэсэн байгаа. Тийм учраас би энэ Улсын Их Хурлын удирдлага, Төрийн байгуулалтын байнгын хорооноос энэ 3 асуултыг дараалж асууж байна аа. Яагаад вэ гэхлээр, би үүнийг Үндсэн хууль зөрчсөн гэж байгаа учраас энэ одоо чиглэлээрээ батлагдах юм бол цаашид Үндсэн хуулийн цэцэд хандах болно оо гэдгээ илэрхийлж байгаа юм. Тийм учраас маш тодорхой хариултуудыг авъя гэж ингэж үзэж байгаа юм.

Г.Занданшатар: Жамъянхорлоогийн Сүхбаатар ажлын хэсгийн гишүүн.

Ж.Сүхбаатар: Эрхэм гишүүн Батсуурийн асуултад хариулъя. Батсуурь гишүүний асуултад бол би Байнгын хороо, ажлын хэсгийн шатанд, өчигдөр бараг үндэсний телевизээр ч бас хариулаад явж байгаа. Ер нь бол хоёр хандлага байгаа шүү дээ. Сая бол Сандаг-Очир гишүүн хүртэл сум, дүүргийн засаг дарга нь баг, хорооны засаг даргаа шууд томилъё гэж байсан. Бидний одоогийн явж байгаа төсөл чинь нэр дэвшүүлэх санал гаргаж байгаа субъект дээр нэмээд оролцъё гэдэг л арай зөөлөн хэлбэрийн зохицуулалт хийсэн шүү. Хэрвээ одоо бусад гишүүдийн тэр бусад өнгөрсөн жил ч гэсэн ярьж байсан асуудал шиг дээрээсээ томилсон бол энэ чинь Монгол Улс одоо ингээд тусгаар тогтнол алдагдаад сөнөчихнө гэж бас ойлгож болохгүй л байх л даа. Хэт хүч оруулж хэлж байх шиг байна. Батсуурь гишүүн. Энэ дээр яригдаж байгаа асуудлууд Үндсэн хуульд тусгагдаагүй ийм зүйлийг оруулж ирж байна аа гэдэг яриа бол байна аа. Гэхдээ бид чинь аль хандлагаар хандаж байна вэ гэж. Томилох хандлагыг нь арай жаахан нэмэгдүүлэх ганц боломж нь зүгээр энэ л байна гэж одоо томьёолж оруулж ирж байгаа юм. Гэхдээ үүнийг ажлын хэсэг санаачилсан юм биш шүү дээ, энэ чинь Улсын Их Хурал дахь олонхын бүлгээс санал гараад л ингээд явсан. Одоо үүнийг чинь ингээд байн байн тэр гээд хэлээд байх хэцүү. Гэхдээ ажлын хэсэг чинь ингээд ч өөрөө бодоод хүсээд, зохиогоод байгаа юм байхгүй шүү дээ. Энэ чинь томьёололд оруулдаг үүрэгтэй шүү дээ, хэлэлцүүлэгт бэлтгэнэ ээ гэж. Тэгээд энэ чинь Үндсэн хууль зөрчсөн гэж бас үзэхгүй байна би бол.

Мэдээж зарим тохиолдолд шүүмжлэлтэй хандах юм гарах ч гэсэн томилгооны тэр элементийг нь онолынх нь хэллэгээр бол томилгооных нь тэр давуу чанарыг нь нэмэгдүүлэх боломж нь нэг ийм аргаар байж болох юм аа л гэж энэ хандлагаар нь асуудалд хандсан. Түүнээс биш тусгаар тогтнол алдагдуулаад нутгийн өөрөө удирдах ёс нь устгаад байх юм байхгүй байх л даа. Үүнийг бол

яах вэ, улс төрийн зорилгоор, тэр улс төрийнхөө байр сууринаас улс төрчийн хувьд бол хэлж байгаа байх. Ер нь иргэд ч гэсэн хүсээд байгаа шүү дээ. Дээд талынх нь улсууд олигтой хүмүүс шууд томилоод өгөөч ээ гээд ингээд л яриад байсан эд шүү дээ. Бүр эсрэгээрээ харин.

Г.Занданшатар: Байнгын хороон дарга хариулах уу? Лувсанцэрэнгийн Энх-Амгалан дарга асуултад оруулна.

Л.Энх-Амгалан: Батсуурь гишүүн ээ. Та бас ажлын хэсэгт байсан. Гол нь яах вэ, бид нарын яриад байгаа энэ концепцын шинж чанартай юм чинь бүх шатны засаг дарга нарыг ингэж чадавхжуулах, ард иргэд нь хүлээн зөвшөөрсөн ийм засаг даргыг томилох энэ боломжуудыг л нээж байгаа юм. Одоо засаглалаа арай жаахан төгөлдөржүүлэх гэх юм уу, тэр чиглэл рүү л хийж байгаа. Ийм боломж олгож байгаа хэлбэр байгаа юм. Одоо бол амьдрал дээр яг энэ сумын иргэдийн хурал, аймгийн иргэдийн хурал, би дүүргийг бол сайн мэдэхгүй байна. Тэгээд л ингээд хэсэг бүлэг улсууд орж ирээд л, ингээд өөрсдийнхөө зөвхөн тэр иргэдийн хурал, тухайн шатны иргэдийн хуралд сонгогдсон улсууд бүлэглэлээрээ засаг дарга тавьдаг.

Ард иргэдийн хүсэж байгаа, хүлээж байгаа, ард иргэдэд хүлээн зөвшөөрөгдсөн ийм асуудал байхгүй. Тэгэхээр дээд шатны засаг дарга гэдэг нь одоо Ерөнхий сайдаас авхуулаад аймгийн засаг дарга, сумын засаг дарга. Мэдээж ард иргэдийн дуу хоолой ард иргэдэд хүлээн зөвшөөрөгдсөн энэ сайн хүмүүсийг нэр дэвшүүлж байж л тэд нарын дэмжлэгийг авна шүү дээ. Иргэдийн хурал, нэр дэвшүүлэх эрх нь байгаа. Тэгэхдээ дээд шатных нь засаг дарга нь дахиад нэр дэвшүүлэх ийм эрх байгаа учраас илүү өрсөлдөөнийг бий болгож байгаа. Нөгөө талаараа олонд хүлээн зөвшөөрөгдсөн, энэ ард иргэдийн бас нэг өгсөн саналыг нь баталгаажуулж байгаа ийм томилгооны ийм шинэ хэлбэр, шинэ концепцууд л байгаад байгаа. Энэ нь илүү боломж олгож байгаа, боломж гэдэг талаас нь л би харж, хандах ёстой л гэж бодож байгаа. Тэрнээс биш одоо юу юугүй тусгаар тогтнолоо алдах ийм хууль бид нар батлаад сууж байна гэж байхгүй шүү дээ.

Г.Занданшатар: Батсуурь гишүүн бас Улсын Их Хурлын удирдлагаас асуусан учраас энэ Үндсэн хуулийн 60.2 бол нэг л утгаар хурлаас нэр дэвшүүлнэ гэж байгаа юм. Аймаг нийслэл, сум дүүрэг, баг хорооны хурлаас нэр дэвшүүлнэ гэж байгаа юм. Өөр хүнийг санал өгөх байдлаар ч гэсэн нэр дэвшүүлэх эрх бол Үндсэн хуультай зөрчилдөнө ажлын хэсэг үүнийг бол Үндсэн хуулийг яагаад тэрнийг өөрөөр тайлбарлах агуулгатай байгаа юм. Тэгээд нэр дэвшүүлснийг дээд шатны засаг дарга томилно нэгдүгээрт нь. Энэ бол Үндсэн хуулийн салаа утгагүй маш тодорхой ойлголт.

Хоёрдугаарт нь багийн нийтийн хурал байна гэж ерөөсөө хэлээгүй. Ажлын хэсэг хүлээж аваагүй. 10 гэрийн дарга нарын хурлыг багийн хурал болоод л 15 ч байна уу? 20 хүн цуглаад л. Тэгвэл төрлийн сонгууль болоод байна. Төрийн сонгууль биш төрлийн сонгууль болоод байна. Төрөл садан, овгийн төлөөллүүд, багийн хурлын ирцийг бүрдүүлээд л багийн даргыг сонгочхоод байна аа гэдэг энэ

юм алга болох юм байгаа. Яагаад гэвэл овог, төрлийн бүлгүүд 10 гэрээсээ бүх төлөөллүүд ирээд очих учраас жинхэнэ нутгийн удирдлага хэрэгжих бололцоо бүрдэх байсан. Ингээд 10 гэрийн дарга нарын хурлаас багийн даргаа нэр дэвшүүлээд багийн дарга, тэр утгаараа бол төрийн албан хаагч болох бололцоо бүрдэх байсан. Багийн даргаа ингээд томилоод сумын засаг дарга нь томилоод явчихдаг. Энэ бол манай нутгийн удирдлагын уламжлалд ч тэр, одоогийн энэ овог аймаг, төрөл садан бүлгэрхэг, нөхцөл байдал ч тэр хамгийн оновчтой хувилбар гэж бид үзэж аравт гэж оруулсныг ажлын хэсэг бол хассан. Эднүүс бол Үндсэн хуулийн зөрчил үүсгэнэ ээ гэж үзэж байна.

Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Одоо санал хураалт явуулна. Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураахад дэмжсэн, дэмжээгүй 3 хүртэл гишүүн үг хэлж болно.

Эхний санал. Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжсэн. Санал хураалтад явуулъя.

1. Төслийн 7 дугаар зүйлд нэмсэн 7.2 дахь хэсгийг хасах.

Санал гаргасан: Төрийн байгуулалтын байнгын хороо.

Үг хэлэхээр хоёр гишүүн нэрээ ирүүлсэн байна. Жамбын Батсуурь, Содномын Чинзориг, Лхагвын Мөнхбаатар, Болдын Жавхлан гишүүн 7.2-ыг хасах дээр. Зөвхөн 7.2-оор л хэлнэ шүү. Жамбын Батсуурь гишүүн Эзэн Чингис хааны танхимаас. 1, 2 дугаар санал хураалт дээр хоёулан дээр нь үг хэлэх санал өгсөн юм байна шүү.

Ж.Батсуурь: Үүний дараагийн заалт юм байна.

Г.Занданшатар: Содномын Чинзориг гишүүн.

С.Чинзориг: Байнгын хорооны энэ 7.2-ыг хасах гэсэн заалтыг бол дэмжиж байгаа юм. Энэ нөгөө хүн амын тооноос хамааруулаад сумдыг татан буулгах, өөрчлөхтэй холбоотой асуудал байгаа юм. Тийм учраас энэ заалтыг хасъя гэж байгаа Байнгын хорооны саналыг дэмжиж байна. Ерөнхийдөө нэг зүйл байгаа юм. Сая Даваасүрэн гишүүн яриад байна. Мөнхцэцэг гишүүн ч яриад байгаа юм. Тэр 56.8-тай холбоотой асуудлаар би уг нь сая үг хэлье гээд тэгээд нэр орсонгүй, үг хэлж чадсангүй. Энэ дээр тэр эхний нэг удаа нэр дэвшүүлээд дээд шатны дарга нь томилоогүй бол дараагийн нэр дэвшүүлэлтийг нээлттэй болгож өгмөөр байгаа юм. Тэгээд өөр хүний нэр дэвшүүлнэ гээд орчихлоор чинь тэр эхний нэр дэвшсэн хүн бол дараа дахин одоо нэр дэвших боломжгүй болчхоод байгаа юм. Бид чинь энэ хуулиар чинь дээд шатны засаг дарга, Ерөнхий сайд нэр дэвшүүлэх эрхтэй байдаг. Тэгээд энэ бодлого чинь Иргэдийн хурал дээр уначих юм бол тэр хүн маань дахин нэр дэвших эрхгүй болоод цоо шинээр хүн дэвшүүлэх ийм нэг асуудал үүсэх нь.

Хоёр дахь асуудал чинь амьдрал баян шүү дээ. Бид нар олонх, цөөнх

зөндөө л болж явдаг. Цөөнх байхдаа ч гэсэн бас зовлонтой, манай намын бодлогын хүн дэвшиж томилогдохгүй байна гээд л дээд шатны засаг дарга, Ерөнхий сайд буцаахаар дахин нэр дэвшүүлээд л, тэгээд л бодлогынхоо хүнийг аймгийн даргаар, сумын даргаар томилуулдаг ийм асуудлууд байдаг. Тэгэхээр энэ асуудлыг бас дахин эцсийн хэлэлцүүлэг дээр дарга чиглэл өгөөд эргэж харах юм уу? Өөр хүнийг нэр дэвшүүлнэ гэхгүйгээр. Хэрвээ эхний нэр дэвшүүлсэн хүн томилогдоогүй бол дахин одоо нэр дэвшүүлнэ гэдэг ийм л томьёололоор явуулмаар байх юм. Тэгээд өөр хүнийг нэр дэвшүүлнэ гэхээр чинь ингээд дотроо одоо нэлээн бужигнадаг байх. Нам дотроо бас одоо өрсөлдөөн үүсгэх гээд. Ингээд ийм одоо маш их хүндрэлтэй асуудал гардаг шүү дээ.

Тийм учраас үүнийг бас эцсийн хэлэлцүүлэг дээр бас эргэж харах одоо боломж байна уу, үгүй юу гэдэг ийм санал байна. Одоо тэгээд бас аргагүй болгомжийг болчих шиг боллоо. Өөр хүнийг нэр дэвшүүлнэ гэдгийг одоо эргэж яримаар л байна даа. Дарга аа, одоо ямар байдаг юм.

Г.Занданшатар: Хассуурийн Ганхуяг гишүүн Жанжин Сүхбаатарын танхим.

Х.Ганхуяг: Иэгээд би яг энэ өнгөрсөн хэлэлцүүлэг дээр бас яг хэлж байсан юм л даа. Энэ ажлын хэсэгтээ Эдийн засгийн байнгын хорооноос, Төсвийн байнгын хорооноос хүмүүс оролцуулаач, Сангийн яамтай хамтарч ажиллаач гэж би уг нь санал тавьж байсан юм. Тэгээд л ярьсаар байтал яг ингээд л орон нутаг баахан орлого олох эрхийг нь нээгээд өгчихсөн. Дээрээс нь одоо яг орсон орлогынхоо дагуу яг тэр хэмжээгээр зардлаа нэмэгдүүлээд явчихна. Тэр угаасаа тодорхой. Ерөөсөө л татвараа нэмэгдүүлснээр яах вэ гэхээр сумын дарга нар чинь бүгдээрээ ланд хоёр зуу авч унана, тэгээд л хотын төвдөө, тэр сумын төвд баахан бүтээн байгуулалтын ажил эхэлнэ. Тэгэхдээ эргээгээд татварын бааз суурь нэмэгдүүлэхийн төлөө ерөөсөө явахгүй. Тэгэхээр нэгэнт одоо ийм байгаа бол 58.1.2, 58.1.3-ыг энэ хуулиас хасах хэрэгтэй. Тэгж байж хариуцлагыг бий болгох ёстой юм. Ерөөсөө энэ хуульд дан хуульч нар оролцсон болохоос биш ерөөсөө эдийн засгийн талаас нь харсан нэг ч хүн алга байна шүү дээ. Эрхийг нь олгож байгаа бол хариуцлагыг яг тэр хэмжээгээр нь нэмэгдүүлэх ёстой шүү дээ. Тэгэхгүй бол одоо энэ чинь ингээд л яах вэ гэхээр сая яг хэлсний дагуу ерөөсөө нэг сая төгрөгийн орлого олдог байсан бол, сая төгрөгийн төсөвтэй байсан бол өөрсдөө наадуул чинь татвараа оногдуулаад л хоёр сая төгрөгийн орлого олдог бол яг тэр хэмжээгээр зардлаа бас нэмэгдүүлчих, тэр хэмжээгээр орон тоогоо нэмэгдүүлж байна. Ийм л хууль болчихлоо. Яалт ч үгүй одоо бид нар хариуцлагын талаас нь ярилцахгүй л бол энэ ерөөсөө явахгүй л харагдаад байна л даа. Одоо тэгээд өр шир ингээд тавих эрхийг нь бас өгчихлөө л дөө. 15.1.16-д одоо концесс болон үнэт цаас гаргах эрхийг нь ингээд олгочихож байгаа юм. Тэгээд энийгээ төлж чадахгүй бол яах юм? Тэгээд бүгдийг нь улсын төсвөөс төлөх юм уу? Үүний талаар ерөөсөө зохицуулалт алга байна шүү дээ, энэ хуулин дотор.

Г.Занданшатар: Цахимаар санал хураалт явуулна. *MyParliamemt -аар.* Тестийн санал хураалт явуулъя. Шалгалтын санал хураалт.

1. Төслийн 7 дугаар зүйлд нэмсэн 7.2 дахь хэсгийг хасах.

Санал гаргасан: Төрийн байгуулалтын байнгын хороо.

Төрийн байгуулалтын байнгын хорооны саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 61 гишүүн оролцож, 39 гишүүн дэмжиж, 63.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийг хасах.

Норовын Алтанхуяг гишүүн, Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүнээр тасаллаа. Норовын Алтанхуяг гишүүн.

Н.Алтанхуяг: Энэ хуулийн төсөл эцсийн хэлэлцүүлэг рүү орчихлоо ингээд батлагдчих байх. Би ер нь дээр нэлээн хэдэн санал хэлсэн юм л даа. Тэгээд энэ 8.2 чинь бол баг нь арватын зохион байгуулалттай байна гэж байгаа юм. Үүнийг би буруу гэж үзэж байгаа юм. Дэмжихгүй гэж байгаа юм. Ер нь би ямар агуулгаар вэ гээд байхаар нь эртүүд бас би саналаа хэлсэн л дээ. Хэдүүлээ, энэ Үндсэн хууль л баримаар байх юм. Би Ганзоригийн өөдөөс хараад суугаад л, хэлээд л байгаа. Үндсэн хуулиар чинь бол баг гээд л дуусаж байгаа шүү дээ, хороо гээд л дуусаж байгаа шүү дээ. Тэгэхээр одоо энэ хуулиар бид нар нэг буруу юм хийж байгаа, би их харамсаж байгаа. Хуучин яах вэ, ингээд хэсэг гээд л байсан л даа. Тэгэхдээ ингэж хуульчлагдаагүй. Одоо тэгэхээр Үндсэн хуулийнхаа заалтыг зөрчөөд сонгуулийнхаа нөгөө бэлтгэл ажлыг хангаад, тэр одоо баг, хорооны цаана бүр ингээд хэсэг гэдэг юмыг хуулиар бий болгож байна. Энэ бол Үндсэн хууль зөрчсөн заалт. Хуучин бол үүнийг ингэж хуульчилж байгаагүй юм.

Энэ багийг арав гэдэг юм чинь бүр болохгүй. Баг гээд л дуусна. Харин багаа яаж бэхжүүлэх вэ, Хороогоо яаж бэхжүүлэх вэ. Иргэдийн үйлчилгээ яавал дээр вэ. Тэгээд тэр дээр үеийнх шиг биш шүү дээ, одоо бол. Дээр нь иргэд өөрсдөө ирж үйлчлүүлэх ёстой шүү дээ. Иргэнд очиж үйлчилнэ гэж юу байх вэ. Одоо ингээд бэлэг тараана, мөнгө тараана, сонгуулийн бэлтгэл хангана гээд л. Үүнийг одоо манай ардын намын 62 маань зориг гаргаад ингээд зөв шийдчихэж болохгүй юм уу? Үндсэн хууль зөрчихгүйгээр шийдчихэж болохгүй юм уу? Би одоо ийм л юм, энэ хасагдаагүй л дээ Тогтохсүрэн дарга аа. Хороо нь хэсгийн зохион байгуулалттай байна 11.2. Хэсгийн хуваарийг хүн амын суурьшил өрхийн тоог харгалзаж дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурал тогтооно гээд ингээд буруутаад байгаа юм. Би тэгэхээр энэ хоёр заалт Үндсэн хууль зөрчсөн шүү. Үндсэн хууль дээр чинь баг, хорооноос цаашаа байхгүй. Тэгээд хэдүүлээ эндээс эхлэхгүй бол тэр намд нэр дэвшүүлэх хэвшүүлэх чинь бол дараачийн асуудал.

Бид нар 1990 онд ингэчихсэн шүү дээ. Байгууллага дээр нам байгуулахыг хориглоод нэг том дэвшил гарлаа гэсэн чинь одоо ингээд орон нутгаар нь байгуулаад орон нутгийнхаа хөлийг бүүр тэр доошоогоо явуулна гэхлээр энэ бол буруу л даа. Ингэхээр л бид нар нөгөө орон нутаг дээр улс төржинө гэдэг чинь. Одоо жишээ нь тэр хэсгийн хорооны даргыг хэн тавих юм? Үзэмжээрээ л тавина

шүү дээ. Намын гишүүд тавигдаж тэнд цалин хөлс авах юм ингээд хуульчлагдаж байна. Үүнийг та нар нэг анхааараад өгөөч ээ, би тэгэхдээ 8.2-ыг хасъя гэдгээр явж байгаа. Цаана нь тэгтэл 11.2 гээд ерөнхий юмнууд чинь бол үлдчихэж байгаа шүү. Та нар маань анхааараарай.

Ер нь би бас эртүүд бас нэг санал хэлсэн шүү дээ. 2024 оноос хэрэгжихээр юмнууд дээр нь хасчихвал яасан юм. Одоо энэ иргэдийн хурлын төлөөлөгчдийн гуравны нэг нь захиргааны албан хаагч байна. Ингээд бид нар хурлаа баллаж байгаа шүү дээ.

Г.Занданшатар: Энэ 11.2 хасагдаагүй л дээ. 11.2-ыг хасаад үүнийг үлдээх ёстой. Жамбын Батсуурь гишүүн Эзэн Чингис хаан танхимаас.

Ж.Батсуурь: Би энэ 8.2-ыг дэмжихгүй, хасах нь зүйтэй гэж үзэж байгаа юм аа. Байнгын хорооны саналыг дэмжиж байгаа юм. Угаасаа Үндсэн хуульд одоо нэгжийн хуульд аймаг, сум, баг гэчихсэн байна, тэгээд баг дотор ахиж зохион байгуулалт хийх нь бол буруу гэж ингэж үзэж байгаа юм. Зохион байгуулалт хийчих юм бол иргэдийн хурал өөрөө бас цалин, орон тоог томилох эрх нь байж байгаа учраас улсын хэмжээнд асар олон орон тоо нэмж гарч ирнэ. Мянга гаруй багийн дор заримд нь нэг, заримд нь хоёр, заримд нь гурван орон тоо гарч ирнэ. Тэр болгоны цалинг аймгийн сумын хурлууд нь батлаад явчих ийм боломж, эрх олгогдох учраас энэ багийн дор дахиж бүтэц байхгүй байх нь бол зөв өө. Эдийн засгийн хувьчлал. Ер нь багийн түвшинд бол багийн дарга нарын хариуцлага суларна бас нэг дарга гараад ирнэ. Дороо бас одоо зардаг хүмүүстэй.

Тийм учраас Байнгын хорооны саналаар үүнийг хасах энэ асуудлыг бол дэмжиж үг хэлж байгаа юм. Баярлалаа.

Г.Занданшатар: Багийн нийтийн хурал гэж байхгүй л юм байгаа юм. Багийн хурлыг 10 гэрээс сонгочихвол тэр их сайн зохион байгуулалт болох юм.

Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн.

Б.Бат-Эрдэнэ: Миний үг хэлэх нэрийг та та мэддэг болчихсон юм байна л даа. Энэ 8.2-ыг нэлээн ярьсан юм л даа. Түрүүн Их Хурлын дарга бол маш тодорхой хэллээ. Бид нарын хамгийн гол зовлон бол одоо энэ орон нутаг дахь улс төржилт, намчирхал, талцал гэдэг юм чинь хэрээсээ хэтэрчихсэн, маш хэцүү ийм нөхцөл байдалтай байгаа л даа. Тэгэхээр зэрэг үүнийг яг доод талаас нь зөв хэлбэрээр өөрсдийгөө төлөөлж чадах хамгийн шилдэг хүмүүсүүдээ илгээх энэ уламжлалт сонгодог энэ хэлбэрийг авсан бол их л чухал байсан юм л даа.

Одоо баг байтугай сумын удирдлагын асуудлыг нам, дээр нь нэмэх нь ах, дүү, хамаатан садныхаа хүрээнд шийдчихээд байгаа энэ толгойны өвчин байгаа шүү дээ. Тэгээд үүнийг жишээлбэл 10 өрхөөс, тэр аравтаас багийн нийтийн хурлаа зохион байгуулаад тэндээсээ хамгийн шилдэг хүмүүсүүдээ гаргаад сумандаа илгээгээд сумаасаа, цаашилбал аймагт, аймгаасаа улсдаа илгээгээд ингээд явбал өнөөдөр энэ улс орны эрх ашигтай холбоотой, тусгаар тогтнолтой

холбоотой, энэ байгалийн баялагтай холбоотой, төсөв, хөрөнгө тендертэй холбоотой, төр, ард түмний нэр барьж авсан зээл бондтой холбоотой энэ элдвийн асуудлуудыг ингээд сууриар нь шийдээд явах уг нь хамгийн зөв зүйл байсан юм. Тэгээд одоо үүнийгээ хасаж байгаа юм байна.

Уг нь түрүүн санал хураагаад хэсэг гээд оруулж ирсэн хэсгийг одоо дэмжихгүй, хасагдсан учраас анхных нь хуулийн төслөөр орж ирсэн энэ санал босоо үлдэх ёстой гэж ойлгож байсан. Тэгээд ажлын хэсэг дээр үүнийгээ хасчихсан юм байна. Би уг нь тодорхой санал хэлсэн. Аравтын зохион байгуулалттай байна гэж оруулах биш, байж болно гээд ингээд оруулаад өгөөч ээ гэдэг ийм санал хэлээд ингээд дэмжихгүй л байгаа юм байна л даа. Тэгэхдээ энэ бол санаагаараа хэлээд байгаа зүйл биш. Үүнийг яг одоо бодит амьдрал дээр зөвхөн нэг сум биш бүхэл бүтэн аймаг зохион байгуулалтад ороод, үр дүн нь одоо амьдрал дээр гараад байгаа учраас ийм зүйлийг л санал дэвшүүлсэн юм л даа. Хэнтий аймаг, Баян-Овоо сум 3 жилийн дотор улсын тэргүүний сум болж чадлаа шүү дээ.

Г.Занданшатар: Тэгэхээр нь яг энэ амьдрал дээр багийн нийтийн хурлыг сайн мэддэг сумын хүн үүнийг бас ойлгох байсан л даа. Манай энэ ажлын хэсэг бас очиж үзсэн юм уу? Төрийн сонгууль биш төрлийн сонгууль боллоо гэж ард түмэн нийтээрээ ярьдаг юм. Тэгээд энэ 2.6-аар бол 20 өрх тутмаас нэгээс доошгүй хүн хорооны хурал дээр, 3 өрх тутмаас нэгээс доошгүй хүн гэхээр яг л төрөл садангийн хэдэн хүн цуглаад л багийн дарга сонгодог, нэр дэвшүүлдэг, энэ юмыг улам төгөлдөржүүлэн баталгаажуулж байгаа. Үүний гол асуудал нь багийн нийтийн хурлын ирц хүрдэггүй, өрх бүрийн төлөөлөл оролцож чаддаггүй. Тэгээд нэг ийм төрлийн сонгууль жалга довны юм бүр анхан шатны нэгж дээр чинь нэг ийм асуудал үүсээд байхаар л энэ нутгийн удирдлагын өөрөө удирдах ёсны чинь зарчим биелэхгүй байна. Тэгэхээр 10 гэр тутмаасаа нэг хүн сонгож явуулаад л багийн хурал хийж болж байгаа юм.

Үндсэн хуульд бол аймаг, сум, нийслэл, сум, дүүрэг, багийн хурлаас гэж байгаа шүү дээ. Тэр бүгдийг нь багийн нийтийн хурал болох ёстой юм уу, аль эсвэл. Тэгээд нэг ийм гол орон нутагт байгаа том асуудлыг шийдэх ийм гарц гаргалгааг бүтээлчээр хуульд нийцүүлж ашиглахгүй, тэгээд үүнийг аравтын зохион байгуулалт гэсэн нэг сонин заалт болгочхоод, тэгээд үүнийгээ эргэж хасна гээд. 32.6 бол Үндсэн хууль яг зөрчинө. Үндсэн хуулийн цэц дээр очно. Яагаад 3 өрх тутмаас нэгээс доошгүй гэж байгаа юм. Багийн нийтийн хурал гэчхээд. Иргэдийн нийтийн хурал гээд тэгээд яагаад 3-аас доошгүй гэж хуульчилж байгаа юм.

Санал хураалтаа явуулъя.

Санал хураалтад 60 гишүүн оролцож, 36 гишүүн дэмжиж, хоёрдугаар санал дэмжигдлээ.

3. Төслийн 12 дугаар зүйлд нэмсэн 12.1.9 дэх заалтыг хасах.

Санал гаргасан: Төрийн байгуулалтын байнгын хороо. Жавхлан гишүүн үг хэлэх юм байна. Наранбаатар гишүүн үг хэлэх юм байна. Ингээд танхимуудаас оролцож байгаа учраас аль аль заалт дээр дэмжсэн дэмжээгүй үг хэлэхээ урьдчилж өгнө. Яг тухайн зүйл заалтаараа л үг хэлнэ шүү.

Ингээд Болдын Жавхлан гишүүн. Яг энэ заалттайгаа л холбоотой.

Б.Жавхлан: Ажлын хэсгийн ахлагч Байнгын хорооны даргын үгийг сонсохоор уг нь зөв яриад байгаа юм. Тэгээд хуулийг нь үзэхээр хууль нь их өөр юм хэлээд байгаа юм. Тэр хэд дэх заалт байв даа.

Г.Занданшатар: Энэ 12.1.9 шүү дээ. Монгол Улсын гадаад бодлогын нэгдмэл байдлыг хангах гэсэн үг үү?

Б.Жавхлан: Энэ 15.1.6 дахь заалт байгаа.

Г.Занданшатар: Үгүй ээ, 15.1.6-аар ярихгүй ээ.

Б.Жавхлан: Үгүй ээ яах вэ. Би үг хэлчихье л дээ. Надад үг хэлэх боломж өгчих л дөө.

Г.Занданшатар: 12.1.9 дээр л үг хэлнэ. Монгол Улсын гадаад бодлогын нэгдмэл байдлыг хангах гэдэг.

Б.Жавхлан: Энэ болохгүй заалт шүү. Үндсэн хууль дээр очоод унана. Бид өөрсдөө нэгдмэл улсын татварын системтэй, төсвийн бодлоготой ийм улс. Энэ заалтаар төсвийн гадуурх төсөв...

Г.Занданшатар: Энэ заалт биш байна аа. Нанзадын Наранбаатар гишүүн.

Н.Наранбаатар: Энэ 12.1.9-ийг хасах санал Төрийн байгуулалтын байнгын хороо оруулж ирж байгаа юм байна. Үүнийг эсрэг байгаа юм. Дэмжихгүй байгаа, энэ заалт байж байх ёстой юм. 12.1.9-д нь Монгол Улсын гадаад бодлогын нэгдмэл байдлыг хангах гээд байж байгаа. Тэгээд үүнийг аваад хаячихаар нөгөө сум, дүүрэг, аймаг маань гадаадын орнуудтай өөрийнхөө хэмжээнд гэрээ, хэлцэл байгуулах ийм эрх нь нээгдээд өгчих юм биш үү. Бид нар чинь бол төсөв, гадаад бодлогынхоо хувьд бол нэгдмэл бодлоготой ийм улс байгаа юм.

Г.Занданшатар: Энэ заалтыг хасаад 77 дугаар зүйл дээр шинэ зүйл нэмж байгаа.

Н.Наранбаатар: Тэгвэл болж байна.

Г.Занданшатар: Тэнд гадаад хамтын ажиллагаа гээд тусдаа заалт нэмж байгаа юм. Үүнийгээ хасаад 77 дугаар зүйл. 6 дугаар санал хураалтыг та харчхаарай.

Санал хураалт.

Санал хураалтад 60 гишүүн оролцож, 35 гишүүн дэмжиж, 58.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Төслийн 25 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“25 дугаар зүйл. Дүүргийн чиг үүрэг

25.1.Дүүргийн чиг үүрэгт дараах асуудал хамаарна:

25.1.1.дүүргийн хөгжлийн үндсэн чиглэл, бодлого, төлөвлөлт, ерөнхий ба хэсэгчилсэн төлөвлөгөө*;*

25.1.2.дүүргийн өмчийн ашиглалт, эзэмшилт, захиран зарцуулалт, хяналт*;*

25.1.3.дүүргийн төсөв, түүний төлөвлөлт, гүйцэтгэл, тайлан, хяналт*;*

25.1.4.хууль тогтоомжид заасан хүрээнд татвар, хураамж, төлбөрийн хувь хэмжээ тогтоох асуудал*;*

25.1.5.дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлт, хуваарилалт, тайлан, хяналт, бусад сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, тайлан, хяналт*;*

25.1.6.худалдаа, үйлчилгээний зөвшөөрөл, хяналт*;*

25.1.7.нийслэлийн хүнс, хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн хөтөлбөрийн хэрэгжилт*;*

25.1.8.дүүргийн цэцэрлэг, сургууль, эмнэлэг, соёлын төв, номын сан, биеийн тамир, спортын цогцолборын барилга, байгууламж, хөдлөх хөрөнгийн ашиглалт, засвар, үйлчилгээ*;*

25.1.9.дүүрэг дэх авто зогсоолын арчилгаа*;*

25.1.10.нийтийн эзэмшлийн зам, талбай, олон нийтийн соёл амралтын хүрээлэн, ногоон байгууламж, арчилгаа, хамгаалалт*;*

25.1.11.оршуулгын газрын үйл ажиллагааны зохицуулалт*;*

25.1.12.дүүргийн гэрэлтүүлэг, арчлалт*;*

25.1.13.дүүргийн төвлөрсөн бус хүн амын унд, ахуйн хэрэглээний уст цэгийн төлөвлөлт, байршил, ашиглалт, хамгаалалт*;*

25.1.14.хог хаягдлын менежмент.”

Санал гаргасан: Төрийн байгуулалтын байнгын хороо.

Мөнхбаатар, Одонтуяа, Пүрэвдорж гишүүн гурваар тасаллаа. Салдангийн

Одонтуяа эрхэм гишүүн үг хэлнэ.

С.Одонтуяа: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Тэгэхээр энэ хуулиар бол ер нь энэ нийслэл, дүүрэг хөгжлийн цоо шинэ концепцод орно гэхэд бол огт тийм зүйл бол харагдахгүй байна. Ер нь бид нар хуулийг яах гэж өөрчилдөг юм, яах гэж хуулийг санаачилдаг юм, баталдаг юм. Тэр тухайн хөгжил дэвшлийг авчрах зүйлийг хийх хэрэгтэй. Энэ бол үнэхээр нэг хоцрогдсон хуучны ийм зүйл байгаа юм. Жишээлэхэд, нийслэл дээр аль нэг ялсан нам нь бид энэ нийслэлд ялалт байгуулах юм бол энэ хүн нийслэлийн засаг дарга болно. Энэ хүний баг нь ийм баг байх юм, Энэ энэ дүүргүүд. Энэ чинь бид нар чинь нэг агаартай, нэг замтай. Тэгэхээр манай ийм ийм дүүргүүдийг, ийм ийм залуучууд, ийм ийм шилдэг багаараа бид нар орж энэ нийслэлийг хөгжүүлэх юм аа гэдэг иймэрхүү концепц байж, байж ард иргэдээсээ сонгож байж авна. Одоо яаж байна. Нам ялсны дараа тэгээд л нэг хүн хэдүүлээ ярьж байгаад л нэгийгээ дарга тавьчиҳдаг. Ямар ч одоо хот байгуулалтын ойлголт байхгүй. Дүүргийн хөгжил мэдэхгүй ийм зүйл бол энэ хуульд бол хүсэн хүлээж байсан хууль болж чадсангүй ээ. Туйлын харамсалтай байна. Одоо та нар суман дээр очоод үз. Яг энэ хуулиар чинь явах юм бол нөгөө сүүлийн 30 жил аймаг дээр, сумын төв дээр нэг хэдэн банкны салбар шатахуун түгээх станцаас өөр юм 30 жилд хөгжилт нь байхгүй л байгаа шүү дээ.

Тэгэхээр энэ дүүргийн чиг үүрэг дээр, ялангуяа 25.1.8 дээр надад санал байна. Энэ чинь босоо бүтэцтэй байгууллагуудын тухай ярьж байна. Өөрөөр хэлбэл цэцэрлэг, сургуулийг дүүрэг үйлчилгээг нь яаж бүрэн хариуцах юм, энэ чинь дандаа нийслэлийн төсвөөс санхүүждэг байгууллагууд. Сургуулийн засвар, тэр доторх тоног төхөөрөмж. Тэгэхээр үүнийг төсвийг нь нийслэлээс зааж өгөхгүй бол дүүрэг энэ чиг үүргийг биелүүлэх ямар ч боломжгүй.

Дээрээс нь энэ 25.1.1 дээр дүүргийн хөгжлийн үндсэн чиглэл, бодлого төлөвлөлт, ерөнхий хэсэгчилсэн төлөвлөгөө маш сайхан юм бичиж байна. Ийм зүйл. Энэ чинь бол үлгэр байсаар байгаад сүүлийн 30 жил энэ дүүргийн газар олголт, дүүргийн энэ хөгжил, төлөвлөгөөг чинь будаа болгосон байхгүй юу. Бүх зөвшөөрлийг нийслэлээс өгнө, дүүрэг нь мэдэхгүй, дүүргийн засаг дарга нь мэдэхгүй байж байтал айлын цонх таглаад л зөвшөөрөл өгчихдөг. Тэр нийслэлийн хүмүүс хэзээ ч дүүргийн иргэдийнхээ өмнө ирж уулздаггүй.

Тийм учраас энэ бол удирдлага хуваагдмал ийм заалтуудаа тодорхой болгох ёстой. Дээрээс нь 25.1.6-д, худалдаа үйлчилгээ, зөвшөөрөл, хяналт, дүүрэг. Энэ бол бас л шал худлаа заалт шүү. Яагаад гэхлээр бүх баар, рестораны зөвшөөрлийг нийслэл өгдөг. Нийслэл өгчхөөд нэг ч удаа иргэдийн өмнө ирж уулздаггүй. Тэгээд нөгөө дүүрэг рүүгээ л хяналтыг нь тавина. Яаж дүүрэг хяналтаа тавих юм. Өөрөө энэ зөвшөөрлийг өгөөгүй юм чинь дүүрэг яаж хяналтаа тавих юм. Ийм заалтууд маш аюултай.

Дээрээс нь энэ газар олголт сүүлийн 30 жилд …/хугацаа дуусав/

Г.Занданшатар: Одоо Лхагвын Мөнхбаатар гишүүн.

Л.Мөнхбаатар: 25 дугаар зүйлийг өөрчлөн найруулж байгаа юм байна. Энэ дүүргийн чиг үүргийг дахин томьёолж оруулж ирсэн байна л даа. Тэгээд яг ямар зарчмын ийм өөрчлөлт орж байгаа юм бол оо. Одоо үүнийг нь ингээд би өмнөхтэй нь тулгаад үзэхээр 25.1.1-ээр энэ дүүргийн ерөнхий ба хэсэгчилсэн төлөвлөгөө гаргах ийм чиг үүргийг нэмсэн байна. Нэмсэн байгаа юм. Энэ бол бас нэлээн хор уршигтай заалт болж магадгүй гэж би бодоод байгаа юм. Энэ дүүргийн ерөнхий ба хэсэгчилсэн төлөвлөлтийн асуудал бол энэ хот байгуулалтын энэ асуудал руугаа орох ёстой. Дүүрэг болгон ингээд ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн төлөвлөгөө гаргаад ирэх юм бол Улаанбаатар хотын хот байгуулалт, нийслэлийн ерөнхий төлөвлөгөө гэдэг зүйлтэйгээ зөрчилдөөд эхэлнэ шүү дээ, амьдрал дээр.

Бодит байдал дээр одоо улс төрийн өөр, өөр намууд дүүргүүдэд бас ялалт явуулж удирдлагад нь гардаг. Энэ хүмүүс чинь эргээд нэгдсэн төлөвлөлт биш энэ хуулийн энэ заалтыг бариад ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн төлөвлөгөө гаргаад ингээд явах юм бол энэ хот байгуулалт гэдэг юм чинь өөрөө дампуурна аа. Тийм учраас энэ заалтыг ер нь авах шаардлага байгаа юм уу гэдгийг одоо ажлын хэсгээс бас тодруулаад үг авч байгаад хариулчихвал зүгээр байна гэж бодоод байгаа юм.

Ер нь Улаанбаатар хот бүхэлдээ нэг ерөнхий төлөвлөгөө, бас хэсэгчилсэн ийм төлөвлөгөөтэйгөө явах ёстой. Тэгээд дүүрэг болгон ингэж байгуулна гэдэг бол зарчмын хувьд буруу шүү гэдгийг одоо энд би бас анхааруулж хэлье ээ гэж бодож байна. Ажлын хэсэг бас энэ үг аваад, энэ талаарх байр сууриа илэрхийлбэл зүгээр байна гэж бодож байна.

Г.Занданшатар: Одоо дэмжсэн нь дэмжээгүй бол үг хэлж байгаа. Асуулт, тодруулга байхгүй.

Л.Мөнхбаатар: Ажлын хэсгээс үг аваад бас хэлж болно шүү дээ. Ер нь өөрөө бол энэ заалтыг чинь бариад Улаанбаатар хотын төлөвлөлт чинь байхгүй болно шүү л гэж хэлэх гээд байгаа юм. Ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн төлөвлөгөө чинь нэг бодлоготой, нэгдмэл бодлоготой явахгүй байх зүйл чинь энэ болно шүү. Тийм учраас энэ бол энэ хуулийн нэг заалт юм шиг мөртөө одоо үр дагавар нь их хортой зүйл болно шүү гэдгийг би бас хэлээд байгаа. Тийм учраас ажлын хэсгийн дээр бас байр сууриа илэрхийлээд зүгээр байгаа юм.

Г.Занданшатар: Барилга хот байгуулалтын хуулиар зүгээр хот байгуулалтын төлөвлөгөө л байгаа юм даа, дүүргийн төлөө гэж байдаггүй л юм.

Бөхчулууны Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: Яг энэ заалттай холбоотой асуудлаар би анхны хэлэлцүүлэг дээр ярьж байсан л даа. Ер нь Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч гэж ярьдаг. Өөрөөр хэлбэл засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хувьд энэ хүн нийслэлийн засаг даргаа хийж байгаа. Онцгой статустай хот болох Улаанбаатарынхаа хувьд энэ хүн Улаанбаатар хотын захирагч гэжд албан тушаал дээр байж байгаа. Тэгэхээр энэ чинь одоо хоёр хуулийн дагуу үйл

ажиллагаа явуулдаг. Өөрөөр хэлбэл одоо засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хууль, мөн түүнчлэн Нийслэлийн тухай хууль гээд ингээд ийм одоо хуулиудаар үйл ажиллагаагаа явуулдаг. Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулиар. Тэгэхээр энэ хууль дээр 24, 25, 26 дээр хотын болон дүүргийн, хороодын үүргүүдийг, ажлуудыг ингээд аваачаад тавьчихсан. Энэ дээр бол засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хуулиар хэрэгжүүлэх ажлыг бол би үлдэх ёстой гэж бодож байгаа. Харамсалтай нь энд яг энэ Улаанбаатар хотын асуудлыг бүгдийг нь авчраад энэ хууль дээр тавьчихаж байгаа нь буруу гэж байгаа юм. Яагаад гэвэл энэ Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулиар тусгагдаад явах ёстой. Өөрөөр хэлбэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль, одоо энэ засаг даргын нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хууль чинь хоёулаа адилхан органик хууль учраас тэнцүү ийм одоо эрхтэй хууль.

Энэ дээр орсноор одоо Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль одоо энд тусгасанаар илүү болчихно гэсэн юм ерөөсөө байхгүй. Тийм учраас энэ заалтуудыг авч хаяад, энэ баахан юм зүйлүүдийг ингээд оруулдгийг нь буруу л гэж үзээд байгаа юм л даа. Харамсалтай нь одоо миний хэлсэн үгийг энэ анхны хэлэлцүүлэг дээр одоо үл ойшоолоо. Тэгээд дээрээс ажлын хэсгийн дарга бас яах вэ ингээд оруулчихъя гэдэг байдлаар хариулт өгсөн. Тэгээд энийгээ бас ингээд тодорхой хэмжээгээр шийдсэнгүй. Тэгэх дээр энэ хууль дээр ийм аж ахуйн яг энэ хотын энэ чиг үүрэгтэй холбоотой ийм асуудлууд орох ёсгүй байсан юм гэдэг ийм зүйлийг хэлж байгаа юм. Баярлалаа.

Г.Занданшатар: Санал хураалт явуулна. Гишүүд үг хэлж дууслаа. Дэмжсэн, дэмжээгүй үг хэлж дууслаа. Санал хураалт.

60 хувиар энэ санал дэмжигдлээ.

5.Төслийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“47.6.Улсын хэмжээний бодлого дэвшүүлж ажиллах үүрэг бүхий улс төрийн нам, эвсэл сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүтцэд аливаа хэлбэрээр зохион байгуулалтын нэгж байгуулахгүй.

Тайлбар: Энэ хэсгийг 2024 оны орон нутгийн ээлжит сонгуулийн дараа өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.”

Санал гаргасан: Төрийн байгуулалтын байнгын хороо. Санал хураалт.

Наранбаатар гишүүн үг хэлнэ. Наранбаатар гишүүнээр тасаллаа. Эрхэм гишүүн Нанзадын Наранбаатар Жанжин Сүхбаатарын танхим.

Н.Наранбаатар: Би үүнийг дэмжиж санал хэлж байгаа юм. Суманд улс төржилтийг багасгах энэ асуудалд бол бас энэ бодитой дэмжлэг болох байх аа гэж бодож байгаа. Тухайлбал улс төрийн нам, эвсэл, сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын бүтэц, аливаа хэлбэрээр зохион байгуулалтын нэгжгүй

байснаараа улс төржилтийг тодорхой хэмжээгээр бууруулах, сумын хурлаас гарах шийдвэрийг бодитой болгоход бас чухал үүрэг нөлөөтэй заалт гэж үзэж байна.

Г.Занданшатар: Наранбаатар гишүүн дэмжиж үг хэллээ.

Санал хураалтад 60 гишүүн оролцож, 36 гишүүн дэмжиж, 60 хувиар энэ санал дэмжигдлээ.

6.Төсөлд доор дурдсан агуулгатай 77 дугаар зүйл нэмж, дугаарлалтыг өөрчлөх:

“77 дугаар зүйл. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн гадаад хамтын ажиллагаа

77.1.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн гадаад хамтын ажиллагаа нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын болон гадаад бодлогын үзэл баримтлалд нийцсэн, гадаад бодлогын нэгдмэл байдлыг баримталсан байна.

77.2.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж нь өөрийн эрхлэх асуудлын хүрээнд гадаад улсын адил түвшний, эсхүл олон улсын байгууллагатай байгууллага хоорондын гэрээ байгуулж болох бөгөөд гэрээг байгуулахдаа гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрөл авсан байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Санал гаргасан: Төрийн байгуулалтын байнгын хороо.

Амартүвшин гишүүн, Пүрэвдорж гишүүд үг хэлнэ. Эрхэм гишүүн Ганибалын Амартүвшин.

Г.Амартүвшин: Баярлалаа. Энэ заалтыг нэмэхийг нь дэмжиж байгаа. Гэхдээ илүү тодорхой болгомоор байна. Миний бодлоор бол нийслэлийн дүүрэг юм уу, одоо сумдын засаг захиргааныхан гадаад, дотоод явж хамтын ажиллагааг гадаад харилцаа хөгжүүлж байгаа нэрийн доор ингээд зугаалж явж, эхнэр, хүүхдийнхээ шопин жагсаалтыг биелүүлээд явж байдаг тийм байдлыг одоо зогсоомоор байна. Монгол улсын төвлөрсөн гадаад бодлого гэж байдаг түүнийхээ дагуу л явмаар байна. Тийм болохоор энэ 77.2-ыг дэмжихгүй, аль эсвэл найруулгыг нь өөрчилмөөр санагдаад байгаа юм. Баярлалаа.

Г.Занданшатар: Одоо эрхэм гишүүн Бөхчулууны Пүрэвдорж.

Б.Пүрэвдорж: Сүүлийн хоёр сонгуулиар манай Ардчилсан нам арчаагүй байсны үр дүнд өнөөдөр Монгол Ардын Нам олонх болоод хэт их олонх болсны зовлонг өөрсдөө үүрээд явж байх шиг байна. Тэгэхлээр хууль тогтоох байгууллага ер нь засаглалыг бүгдийг нь одоо гартаа авч байгаа. Хууль тогтоох байгууллага бол олонх болчихсон үйл ажиллагаа явуулж байна. Гүйцэтгэх засаглал 100 хувь ингээд явж байна. Дээрээс нь шүүх засаглалыг одоо өөртөө авах ийм хуулийг

хийгээд явж байгаа. Өөрөөр хэлбэл нэг намын гарт Их Хурал дээр аль эсвэл одоо Засгийн газарт эрхийг нь авахаар ингээд явж байна.

Албан бусаар дөрөв дэх засаглал гэж ярьдаг хэвлэлийг тэр чигээр нь дуугүй болгосон. Одоо Хууль зүйн сайд нь иргэдийн үгийг хэлэх эрхийг хаах хуулийн төсөл боловсруулаад явж байна. Бүх түвшинд нь дуу амыг нь хаах ийм бодлого явж байгаа. Тэгэхлээр яг өнөөдөр энэ хуулиар энэ нутгийн өөрөө удирдах ёсыг уландаа гишгэсэн хэд хэдэн заалтыг оруулж байгаа. Дээд шатны дарга, Ерөнхий сайд нь аймгийн засаг даргыг санал болгоно, шалтгаангүй буцаана. Мөн түүнчлэн дахин нэр дэвшүүлэх, тэр хүнийг дэвшүүлэхгүй гэдэг ийм нутгийн өөрөө удирдах ёсны энэ бүх зүйлд харшилсан ийм зүйл явж байна.

Дээрээс нь төрийн олон одоо чиг үүргүүд бүгдээрээ дээрээсээ томилгоотой болчихсон байгаа. Ингээд босоо тогтолцоотой социализмын хэлбэр лүү бүх шатандаа Монгол улс одоо ингээд орж байна. Тийм учраас Ардчилсан нам өөдтэй байх хэрэгтэй байна. Өнөөдрөөс эхлээд эв нэгдлээ хангаж, энэ шударга ёс энэ хувь хүн бизнесийн эрх чөлөөний төлөө тэмцэх, илүү зохион байгуулалтад орох ийм одоо шаардлага өнөөдрөөс эхлэн урган гарч байна. Тийм учраас бид нар бол эрх баригч болно. Тэр болох үедээ.../хугацаа дуусав/.

Г.Занданшатар: Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн.

Ж.Бат-Эрдэнэ: Би энэ төслийн 5 дээр үг хэлэх гэж байсан юм л даа. Хоцорсон ч гэсэн хэлье. Энэ улсын хэмжээний бодлого дэвшүүлж ажиллах үүрэг бүхий улс төрийн нам гэж ер нь ямар намыг хэлэх юм бэ. Энэ чинь нам эвсэл гээд явчихдаг энгийн нэр байгаа шүү дээ. Тэгээд энэ үг, үсэг дээр нь анхааараач ээ гэж хэлэх гэж байсан юм. Баярлалаа.

Г.Занданшатар: Гишүүд үг хэлж дууслаа. 47.6-г найруулга дээрээ анхааараарай гэж байна. Өөр нам бол нэгж байгуулж болно. Улсын хэмжээний бодлого дэвшүүлдэг нам бол болохгүй гэсэн агуулга сонсогдоод байна шүү дээ гэж хэлж байна. Тэр чинь 2027 оноос үйлчлэх юм. Тэр хууль чинь 2027 оноос үйлчилнэ. Улсын хэмжээний бодлого дэвшүүлэх чинь.

Санал хураалт. Найруулга дээр үүнийг анхааръя.

Санал хураалтад 60 гишүүн оролцож, 38 гишүүн дэмжиж, 68.3 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

Одоо Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулна.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын

тухай хуулийг хэрэгжүүлэх бэлтгэлийг хангах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 61 гишүүн оролцож, 42 гишүүн дэмжиж, 38.9 хувийн саналаар тогтоолын төсөл батлагдлаа.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлах, бэлтгэл хангуулахаар Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүллээ. Редакцын болон найруулгын засварууд Их Хурлын гишүүдээс өгсөн найруулга редакцын чиглэлүүдийг эцэслэн батлах бэлтгэлдээ Төрийн байгуулалтын байнгын хороо анхаарах чиглэл өгч байна.